

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ



ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

ДУГААР 2025 №2 (11)

ᠰᠣᠩᠭᠤᠯᠢᠢᠨ
ᠪᠣᠯᠣᠪᠣᠰᠣᠷᠣᠯ
ᠣᠨᠣᠯᠤᠰ
ᠠᠷᠭᠠ
ᠵᠦᠢᠨ
ᠰᠡᠲᠭᠦᠭᠦᠯ



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НӨХӨН СОНГУУЛЬ-2025

2025.06.22
07:00-20:00
(Улаанбаатарын цагаар)



www.m-election.mn



GECMongolia



Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо

МОНГОЛ УЛС АЗИ ТИВЭЭС АНХ УДАА
НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ (ОГР)-ИЙН
УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ
ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ СОРИЛТОД НЭГДЛЭЭ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Б.Цэцэгдэлгэр

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан референт-хэвлэлийн төлөөлөгч

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

ГИШҮҮД

Т.Дорж

Академич, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор

Д.Дашпүрэв

Философийн шинжлэх ухааны доктор, профессор

Д.Гангабаатар

Хууль зүйн доктор, профессор

Д.Даваа-Очир

Хууль зүйн доктор, профессор

З.Сүхбаатар

Бизнесийн удирдлагын доктор, профессор

О.Хатанболд

Улс төр судлалын доктор

А.Эрдэнэцогт

Хууль зүйн доктор, профессор

Д.Бат-Эрдэнэ

Хууль зүйн магистр

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын Гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

"Чимид сан"-ийн Гүйцэтгэх захирал

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн Удирдах зөвлөлийн ахлагч

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

4

СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ

- Сонгуулийн тойрог, хэсэг хоёр

8

НИЙТЛЭЛ

- Улс төрийн нам (харьцуулсан судалгаа)

11

ХУУЛЬ ТОГТООМЖ

- Улс төрийн намын нээлттэй мэдээлэл
- Улс төрийн намд төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг
- Улс төрийн намд төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг
Н.Булгамаа: Бүх нам санхүүгийн тайлангаа гаргах, тайлан нь нийтэд ил тод байх зохицуулалттай
- Монгол Улс Ази тивээс анх удаа Нээлттэй Засгийн Түншлэл (OGP)-ийн улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах сорилтод нэгдлээ
- Нээлттэй Засгийн Түншлэл (open government partnership)-ийн "Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах" сорилтод нэгдэхийн ач холбогдол
- Улс төрийн намын санхүүжилтийг тайлагнах цахим шийдлүүдийн туршлагыг хэлэлцэв

23

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН НӨХӨН СОНГУУЛЬ-2025

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль -2025
- Сонгогчдын нэрийн жагсаалт
- Нам, эвсэл, нэр дэвшигчийн бүртгэл
- Сурталчилгаа

36

СОНГУУЛИЙН ЦАХИМ СИСТЕМ E-ELECTION.MN

- С.Тамир: Нөхөн сонгуулийн дүнг цахим хуудсаар мэдээлнэ

39

ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ

- Сонгогч саналаа өгөх дараалал, анхаарах болон хориглох зүйл
- "Хариуцлагатай сонгогч" сургалт
- "Сонгуулийн боловсрол" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага

44

СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙ

- "СОНГУУЛЬ-2024" ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ
"Жендэрийн тэгш эрхийг хангахад Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн хууль тогтоомж, улс төрийн намын тухай хуулийн үзүүлсэн үр нөлөө"

50


СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД

- Улс төрийн намын эрх зүйн байдлыг Үндсэн хуульдаа хэрхэн тодорхойлсон талаарх харьцуулалт

53

ГАДААД ХАРИЛЦАА

- ХБНГУ-ын Бундестагийн сонгуулийг ажиглалаа
- "Хиймэл оюун ухаан-сонгуульд оролцогч талууд" семинарт оролцов



СОНГУУЛИЙН ТОЙРОГ, ХЭСЭГ ХОЁР*

Бяраагийн ЧИМИД

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор



3.1. ТОЙРОГ ГЭЖ ЮУ БА ТҮҮНИЙ ҮҮРЭГ

Сонгуулийг нутаг дэвсгэрээр зохион байгуулдаг. УИХ-ын сонгуулийн хувьд улсын нутаг дэвсгэрийг тойрогт, тойргийг хэсэгт хуваана.

Тойрог бол “тулалдааны гол талбар” юм. Энд л та сонгох, сонгогдох эрхээ эдэлж, хэрэгжүүлдэг. Тухайлбал, Та гишүүнд нэрээ бие дааж дэвшүүлэх буюу нам, эвслээс нэр дэвшүүлэхэд оролцох, дэмжих, тэдэнтэй болон бусад өрсөлдөгчидтэй уулзаж, үг яриа, үүрэг амлалтыг нь сонсож, дүгнэн цэгнэнэ. Хэний, аль нам эвслийн төлөө саналаа өгөхөө товлон урьдчилсан шийдвэрээ гаргана. Үүнд тойрог ямар үүрэг, ач холбогдолтой вэ?

Төрийн болон нутгийн төлөөлөх байгууллагыг сонгох ажлыг **тойргоор** зохион байгуулна. Дотор нь сонгогчдыг хэсэг болгон хувааж санал хураадаг. Энэ бүхнээрээ **тойрог бол сонгуулийн ажлын зохион байгуулалтын гол хэлбэр** мөн. Түүний үүрэг нь:

- Сонгогчдыг оршин суугаа нутаг дэвсгэрээр нь хуваарилж зохион байгуулах;
- Сонгуулийн өмнөх цогц үйл ажиллагааг чиглэсэн зорилготой төвлөрүүлж явуулах;
- Сонгогчдоос өөрсдийн төлөөлөгчөөр сонгох хүнээ нийтлэг ашиг сонирхлын дагуу тодруулан саналаа илэрхийлэх;
- Сонгогчдын саналыг нэгтгэн дүгнэж, сонгогчдыг тодруулах;
- Улмаар сонгогдсон гишүүнтэй холбоотой байж УИХ, ИТХ-тай харилцах гол суваг, зохион байгуулалтын үндсэн хэлбэр болдог.

Хүн ам, сонгогчдын нийтлэг эрэлт хэрэгцээ, засаг төрд хандаж уламжлах аливаа асуудал нь чухамхүү тойргийн хэмжээний “ашиг сонирхол” болон нэгдмэл нэг утга санаа болж цогцолно. Энэ бүхэн тойрог бол сонгуулийн ажлын зохион байгуулалтын гол хэлбэр гэдгийг харуулдаг.


3.2. ТОЙРОГ ХЭДЭН ЯНЗ БАЙДАГ ВЭ?

УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн тойргийг зохих нутаг дэвсгэрийг хуваарилж түүний хилийг тогтоож, төвийг нь тодорхойлон байгуулна.

Улс, аймаг, сумын нутаг дэвсгэрийг бүхэлд нь тэдгээрийн **сонгуулийн газар зүй** гэх бөгөөд тойрог бол түүний нэгж юм.

Сонгуулийн тогтолцоо, зохион байгуулалтын зарчмаас хамааран тойрог нь:

- нэгдмэл тойрог
- нэг мандаттай тойрог
- олон мандаттай тойрог гэж гурван төрөл зүйл байна.



Бүдүүвчээс үзвэл: УИХ-ын 76 гишүүнийг зөвхөн нэг тойргоор сонгох бол улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь **“нэгдмэл тойрог”** гэнэ. Харин нэг тойргоос 2 ба түүнээс дээш тооны гишүүн сонгох бол **“олон мандаттай”**, тойрог бүрээс 1 гишүүн сонгох бол **“нэг мандаттай”** тойрог гэнэ.

Үүнээс гадна сонгуулийн тойргийг нутаг дэвсгэрээр бус, үйлдвэрлэлийн болон үйлдвэрчний эвлэлийн, эмэгтэйчүүдийн, цэргийн, хөдөлмөрийн хамт олны, үндэстний цөөнхийн гэх зэрэг хүмүүсийн нийтлэгийн өөр өөр шинж байдлаар зохион байгуулдаг жишиг улс орнуудад

байдаг.

Монгол Улсын сонгуулийн орчин цагийн тогтолцоо бий болсноос хойшхи түүхээс үзвэл УИХ-ын сонгуулийг:

1. 1951 оноос 1990 онд нэг мандаттай тойргоор;
2. 1992 онд 1 тойргоос 2-4 хүн буюу олон мандаттай бүгд 26 тойргоор;
3. 1996, 2000, 2004 онд нэг мандаттай 76 тойргоор зохион байгуулжээ.

Харин 2006 онд баталсан “Улсын Их Хурлын сонгуулийн хууль” ёсоор УИХ-ыг олон мандаттай тойрог байгуулж сонгох болжээ.

СтХ-ийн 12 дугаар зүйлээс:

“12.1. Улсын Их Хурлын 76 гишүүнийг сонгох сонгуулийг олон мандаттай тойргоор зохион байгуулж явуулна.

12.2. Улсын Их Хурал олон мандаттай тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн санал авах өдрөөс зургаан сараас доошгүйн өмнө байгуулж, тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно.”

3.3. ТОЙРОГ БАЙГУУЛАХАД ЮУГ ХАРГАЛЗДАГ ВЭ?

Дээрх заалтаас үзвэл УИХ сонгуулийн тойрог байгуулах шийдвэрийг сонгуулийн өдрөөс **6 сарын өмнө** гаргана. Энэ бол зөвхөн хугацаа, зохион байгуулалтын чанартай асуудал биш. Харин их бодож, журамлаж шийддэг орон нутаг, иргэдийн болон улсын ашиг сонирхлыг хосолсон түвэгтэй асуудал билээ. Тойрог байгуулахдаа сонгуулийн зарчмын тухай онолын үндэслэлтэй шалгуурыг харгалзах ба хуульд заасан шаардлагыг баримтална.

Онолын хувьд бол:

- сонгуулийн тэгш эрхийн зарчмыг хангах;
- үүний тулд хүн амын тоог тойргуудад адил буюу ойролцоо байх;
- нэг сонгогч нэг тойрогт саналаа нэг удаа өгөх шаардлагыг хангах учиртай юм.

Улс орнуудад тойргийн хүн амын тоог тодорхойлохдоо улсын нийт хүн амын нэгдсэн тооллогын дүнг үндэс болгодог. Хүн амын улсын ээлжит нэгдсэн тооллогыг АНУ 10 жилд, Англи 15 жилд нэг удаа явуулдаг байна. Иймд Англи бол 15 жилд нэг удаа сонгуулийн газар зүйг “хянан үздэг” гэсэн үг болно.

Монгол Улс хүн амын нэгдсэн тооллогыг 10 жилд нэг удаа явуулж байхаар хуульчилж, 2000 онд улс даяар явуулсан. Энэ тооллогын дүнг 10 жилдээ аймаг, нийслэлийн хүн амын тоо гэж баримтлахаар тогтсон юм. Гэсэн хэдий ч сүүлийн хэдэн жилд иргэдийн шилжилт хөдөлгөөн урд байгаагүйгээр ихсэж ЗЗНД-ийн нэгжүүдийн “суугуул” хүн амын тоо ихэд өөрчлөгдсөн байна. Энэ байдлыг харгалзан 2008 оны сонгуулийн наана хүн ам (сонгогчдын)-ын тоог

тойрог хэсэг тус бүрд нарийн тооцож гаргах арга хэмжээ улс даяар авч байна.

Засгийн газрын 2008 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоолоор хүн амыг нарийвчлан тоолж сонгуулийн өдрөөс 4 сарын өмнө тойрог, хэсэг нэг бүрээр тоолж дүгнээд нэрийн жагсаалтыг түүний дагуу гаргах болов.

Бусад орны жишгээр үзвэл тойрог байгуулахад парламентын бүтцийг бас харгалздаг. Монголын парламент бүтцийн хувьд нэг танхимтай. Энэ нь энгийн (холбооны бус) бүтэцтэй нэгдмэл улсуудын дийлэнх олонхийн жишигтэй дүйдэг юм. Хоёр танхимтай парламент ихэвчлэн холбоот улсын жишиг. Тэнд нэг танхим нь үндэстэн-төр буюу муж улсыг, нөгөө танхим нь нийт улсын ашиг сонирхлыг төлөөлж илэрхийлдэг юм. Жишээ нь: АНУ-ын Конгресст нийт холбоогоо бүхэлд нь төлөөлж сонгогдсон Төлөөлөгчдийн танхим гэж байхад 50 муж улсаа тус, тусад нь төлөөлөн хоёр хоёроороо сонгогдсон (50*2=100) сенат буюу сенатчдын танхимтай. ХБНГУ-д холбоот улсаа бүхэлд нь төлөөлсөн “Бундестаг” гэж байхад гишүүн улс (“Ланд”)-аа төлөөлж тус тусынх нь Засгийн газраас томилон илгээсэн “Бундесрат” гэж байна. АНУ-ын “Сенат”, Германы “Бундесрат”-ын гишүүд нь муж улсынхаа ашиг сонирхлын төлөө маргаж тэмцэлдэж байхад нөгөө нийтийн танхимын төлөөлөгчид тэгж “явцуурахгүй” улсынхаа нийтлэг ашиг сонирхлыг гол болгон мэтгэлцэнэ гэх жишээтэй.

Нэг танхимт бүтэц бүхий парламентын гишүүн нь голчлон нийт улсын ашиг сонирхлыг илэрхийлэхийн хамт тойргийнхоо сонгогчид, тэдний хамт (аймаг, сумын зэрэг)-ын ашиг сонирхлыг бас харгалзаж төрийн бодлого, үйл ажиллагаанд тусгана. Энэ бол бодит хэрэгцээ гэсэн үг. Үүнийг харгалзан УИХ-ын сонгуулийн томсгосон тойрог байгуулахдаа аймаг хооронд, түүнчлэн нийслэл дэх дүүрэг хооронд хүн амын тоог гишүүний мандатын тоогоор ойртуулж тэнцэтгэхийг зорьжээ. Үүний зэрэгцээгээр ЗЗНД-ийн хуваарь буюу аймаг, сум, нийслэлийн дүүргийн хүн амын байршил, засаг захиргаа-нутаг дэвсгэрийн байгууламжийн бүтэц, нэгжийн тоо, бүрэлдэхүүний үлэмжхэн ялгааг харгалзахаар хуульд заасан байна.

СтХ-ийн 12 дугаар зүйлээс:

«12.3. Аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо нь тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймаг, нийслэлийн дүүрэгтэй нэгтгэн нэг тойрог болгоно.

12.4. Тойрог байгуулах хүн амын тооны улсын дунджийг аймаг, нийслэлд ялгавартайгаар тогтооно».

Энэ заалтаас үзвэл тойргийг байгуулахдаа бүтцийн хувьд ЗЗНД-ийн дээд нэгж буюу аймаг, нийслэлийг үндэс болгосон байна. Түүний дотор хүн амын дунджийг аймгуудад нэг адил, нийслэлийн дүүргүүдийн хувьд нэг адил байх зарчмыг баримталжээ. Энэ бол манай улсын нийт хүн амын бараг тэн хагас нь нийслэлд оршин сууж байгаа онцлогтой шууд холбоотой юм. Улс орон гэдэг нь зөвхөн Улаанбаатар хот бус, улс төрийн бодлого, төрийн үйлчилгээ гэдэг гагцхүү “дөрвөн уулын дунд” биш билээ. Харин нийт нутаг дэвсгэр

болох 21 аймаг, 320 гаруй сум, 1540-өөд багийг хамаардгийг бодолцсон хэрэг юм. Өөрөөр хэлбэл, ганц хүн амын тоог тэгшитгэн баримталбал УИХ-ын гишүүний бараг 50 хувийг нийслэлээс сонгомоор. Гэтэл нутаг дэвсгэрийн 90 гаруй хувь болох хөдөөд сумын тоо дүүргийнхээс 36.5 дахин, багийн тоо хорооныхоос 12.8 дахин олон байна. Иймээс хүн ам нь ихээхэн өргөн уудамд тархаж оршдогийг бас онцлон харгалзаж төлөөлөх шаардлагатай болдог аж. Нийслэлийн 9 дүүрэг, 120 гаруй хороог 20 гишүүн, түүнээс хэдэн арав дахин олон сум багийг 56 гишүүн төлөөлөх болж байгаа юм. Энэ бол улсын бүтэц, нутаг дэвсгэр, хүн амын тархцаас, тэдэнд үйлчлэх боломжоос шууд хамаарсан явдал болно.

УИХ энэ бүхнийг харгалзан Сонгуулийн ерөнхий хорооны саналын дагуу 2007 оны 12 дугаар сарын 27-ны 9 дүгээр тогтоолоор УИХ-ын 2008 оны сонгуулийн тойргийг байгуулж, мандатын тоог хуваарилжээ.

3.4. УИХ-ЫН 2008 ОНЫ СОНГУУЛИЙН ТОЙРОГ

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Тойргийн төв	Нэгдэх мандатын тоо
1	Архангай	Эрдэнэбулган сум, Аймгийн ЗДТГ	3
2	Баян-Өлгий	Өлгий сум, Аймгийн ЗДТГ	3
3	Баянхонгор	Баянхонгор сум, Аймгийн ЗДТГ	3
4	Булган	Булган сум, Аймгийн ЗДТГ	2
5	Говь-Алтай	Есөнбулаг сум, Аймгийн ЗДТГ	2
6	Дорноговь, Говьсүмбэ	Сайншанд сум, Аймгийн ЗДТГ	2
7	Дорнод	Хэрлэн сум, Аймгийн ЗДТГ	3
8	Дундговь	Сайнцагаан сум, Аймгийн ЗДТГ	2
9	Завхан	Улиастай сум, Аймгийн ЗДТГ	3
10	Өвөрхангай	Арвайхээр сум, Аймгийн ЗДТГ	4
11	Өмнөговь	Даланзадгад сум, Аймгийн ЗДТГ	2
12	Сүхбаатар	Баруун-Урт сум, Аймгийн ЗДТГ	2
13	Сэлэнгэ	Сүхбаатар сум, Аймгийн ЗДТГ	3
14	Төв	Зуунмод сум, Аймгийн ЗДТГ	5
15	Увс	Улаангом сум, Аймгийн ЗДТГ	3
16	Ховд	Жаргалант сум, Аймгийн ЗДТГ	3
17	Хөвсгөл	Мөрөн сум, Аймгийн ЗДТГ	4
18	Хэнтий	Хэрлэн сум, Аймгийн ЗДТГ	3
19	Дархан-Уул	Дархан сум, Аймгийн ЗДТГ	3
20	Орхон	Баян-Өндөр сум, Аймгийн ЗДТГ	2
21	Хан-Уул, Баганхангай, Баянзүрх дүүрэг	Хан-Уул дүүргийн ЗДТГ	2
22	Баянзүрх, Налайх дүүрэг	Баянзүрх дүүргийн ЗДТГ	4
23	Сүхбаатар дүүрэг	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	3
24	Чингэлтэй дүүрэг	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	3
25	Баянгол дүүрэг	Баянгол дүүргийн ЗДТГ	4
26	Сонгинохайрхан дүүрэг	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	4

Хүснэгтээс үзвэл хоёр мандаттай тойрог 8; гурван мандаттай тойрог 12; дөрвөн мандаттай тойрог 6 байна. Эдгээр тойрог 2008 оны сонгуулийн турш төдийгүй, хэрэв дараагийн сонгуульд өөрчлөлт оруулахгүй бол нэгэн адил хүчинтэй хэвээр байх болно. Харин дараах үндэслэл байвал УИХ Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн сонгуулийн өдрөөс 6 сарын өмнө өөрчлөн байгуулж болно.

СтХ-ийн 12 дугаар зүйлээс:

«12.5. Сонгуулийн ерөнхий хороо тойргийг өөрчлөх тухай саналыг дараахь тохиолдолд Улсын Их Хуралд оруулна:

12.5.1. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь өөрчлөгдсөн нь тойргийн зохион байгуулалтад нөлөөлөхөөр байвал;

12.5.2. тойргийн хүн амын тоо нь өмнөх сонгуулиас хойшхи хугацаанд 20-иос дээш хувиар өөрчлөгдсөн бол».

«12.6. Улсын Их Хурал тойргийг өөрчлөх тухай асуудлыг энэ хуулийн 12.2-т заасан хугацаанд багтаан шийдвэрлэнэ.»

Тойрог байгуулахдаа: «Нутаг дэвсгэр, төвийг заана» гэж СтХ (12.2)-д заасан ёсоор дээрхи аймаг, дүүргийн нэрийг зөвхөн тойргийн нэр биш, харин тэдгээрийн нутаг дэвсгэрийн хууль ёсны (УИХ-аас баталсан) хил гэж ойлгоно. Тэр хилийн дотор сонгуулийн өдөр оршин байгаа (саналаа урьдчилан өгөөд өөр газар зорчин явснаас бусад) хэн боловч тэр тойрогт харьяалагдах нэг л хэсэгт бүртгүүлж саналаа өгнө.

3.5. СОНГУУЛИЙН ХЭСЭГ ТАНЫ ОРОН ГЭЭ

3.5.1. Сонгуулийн хэсэг гэж юу вэ?

Хэсэг нь тойргоос хэр ялгаатай, ямар үүрэгтэй вэ? Сонгууль хийгээд сонгогчдод хэр ашиг тустай вэ? гэдгийг бодож үзээрэй.

Тойрог бол УИХ-ын гишүүнд нэр дэвшигчид тэднийг дэмжигчдийн өрсөлдөөний талбар, сонгуульд ялж гишүүний (мандат) бүрэн эрхийг олж авах өлгий нутаг нь болно. Тэгвэл сонгуулийн хэсэг нь уул тойргийн нутаг дэвсгэрийн нэгээхэн хэсэг юм.

Сонгогчдыг оршин суугаа газрын ойролцоогоор нь хэсэглэн бүртгэж оролцуулах, саналаа саадгүй гаргах аятай боломж бүрдүүлэхийн тулд тойргийн нутаг дэвсгэрийг хэсэгчлэн хуваадаг. Тэнд сонгогчдыг өөр хэсэгтэй давхардуулалгүй бас хийдүүлэхгүй бүртгэж нэрийн жагсаалтад бичдэг. Сонгогчийн үнэмлэх олгодог. Санал өгснийг нь тэмдэглэж тооцдог. Иймд сонгуулийн хэсэг байгуулж ажиллуулахын гол зорилго нь «Сонгогчдын санал авах, тоолох» ажлыг төвлөрүүлж зохион байгуулах явдал юм (СтХ-13.1).

Эцсийн дүнд хэсэг бол сонгогчдыг саналаа өгөх газраар нь нэгтгэсэн, сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийн нэгж мөн.

Та зөвхөн энд л нэрсийн жагсаалтад бичигдэж, түүний дагуу сонгогчийн үнэмлэх авч, төвд нь хүрэлцэн ирж эсвэл явуулын хайрцгаар саналаа өгнө. Үүнээс үзвэл сонгогчийн хувиар төрдөө данслагдаж, гишүүний төлөө эцсийн шийдлээ гаргадаг голомт газар нь сонгуулийн хэсэг болой.

3.5.2. Сонгуулийн хэсгийг байгуулах

Хэсгийг СтХ-д зааснаар байгуулах тул энэ бол хууль ёсны зохион байгуулалт мөн.

СтХ-ийн 13 дугаар зүйлээс:

«13.1.Сонгогчдын санал авч тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хэсгийг санал авах өдрөөс 35-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, хэсгийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг зарлана».

Сонгуулийн хэсгийг:

- хөдөөгийн сумдад 2000 хүртэл;
- аймгийн төвийн сумдад 3500 хүртэл;
- Улаанбаатарт 6000 хүртэл сонгогчтой байхаар тооцож;
- сонгуулийн өдрөөс 35-аас доошгүй хоногийн өмнө тухайн сум, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчид байгуулж тогтоол гаргаж нийтэд зарлана.

Тогтоолд:

- хэсгийн дугаар;
- нутаг дэвсгэр;
- төвийг тус тус заана.

Хэсэг байгуулахдаа хуулиар тогтоосон энэ ерөнхий зарчим, хязгаарыг зөв хэрэглэх нь чухал. Ялангуяа хэсгийн нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчдын байршил (бөөгнөрөл, тархац)-ын онцлог, сонгогчдоос хэсгийн төвд хуулийн хугацаанд хүрэлцэн ирж саналаа өгөх зам харилцааны боломжийг сайтар харгалзах нь зүйтэй байдаг.

Хөдөөд бол баг бүрт тэдгээрийн төвд саналаа өгөхөөр, хот сууринд бол төвөөс алслагдсан тосгон суурин, хороо, түүнчлэн цэргийн анги салбар, томоохон эмнэлэг зэрэгт төвлөрүүлэн сонгуулийн хэсэг байгуулж ирсэн туршлага бий. Сонгуулийн төлөө хүн биш, хүний төлөө л сонгууль байдаг шүү дээ.

Манай сумдын 60 гаруй хувь нь 2000 хүрэхтэй, үгүйтэй сонгогчтой байгаа. Энэ чинь дээр дурьдсан "2000 хүртэл" гэсэн тоог баримтлаад ганцхан хэсэг байгуулчихвал юу болох вэ? Сумын хүн ам ихэвчлэн 3-5 багт хуваагдан тархан суудаг. Ийм нөхцөлд ганц хэсэг болговоос иргэд бүгдээр сумын төвд ирж санал хураалтад оролцож амжихгүй болж магад. Аль нэг нам, нэр дэвшигч сонгогчдыг машинаар зөөж цуглуулах нь саналаа сайн дураар чөлөөтэй өгөх зарчмыг хөндөхөөс эхлээд "хэнийг хэн авчирч дотносов, хэнийг гэрт нь орхиж гадуурхав" гэхчилэн хардлага, маргаанд ордог.

УИХ-ын сонгуулийн хэсгийн тоо

Сонгууль болсон он	1992	1996	2000	2004
Хэсгийн тоо	1569	1586	1601	1645

2008 оны сонгуульд УИХ-ын сонгуулийн тойрогт 1600 гаруй хэсэг байгуулагдаж тойрог, хэсэгт 17'000-18'000 орчим сонгогч хороодын гишүүнээр томилогдон ажиллана. Хамгийн гол нь хүний тоо олон цөөндөө бус, тэд шулуун шударга, сургуу шуурхай ажиллахад оршвой.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН



УЛС ТӨРИЙН НАМ

..... (харьцуулсан судалгаа)



Монгол Улсын Үндсэн хууль (1992)

» Арван зургадугаар зүйл... 10) нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.

Улс төрийн намын тухай хууль (2023)

- » 4.1. Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.
- » 7.1.7. олон улсын байгууллага, бусад орны нам, байгууллагатай хамтран ажиллах, улс төрийн намуудын олон улсын байгууллагад гишүүнээр элсэх.



**АКАДЕМИЧ
Ж.АМАРСАНАА**

1.

УЛС ТӨРИЙН НАМ ХЭРХЭН ҮҮСЧ БИЙ БОЛОВ?

Нам гэдэг нь (латин хэлний *pars, parties*) хэсэг, оролцоо, хувь, тал, харилцаа, төрөл, манлайлал, оролцогч гэсэн олон утгатай үг аж. Нам нь бусад олон нийтийн байгууллагаас өөрийн зорилгоороо эрс ялгагдах онцгой нэгдэл юм. Нам бол олон нийтийн байгууллага мөн. 1997 онд УИХ-аас Үндсэн хуулийн заалтыг зөрчиж Төрийн бус байгууллагын тухай хууль баталжээ. Түүнчлэн олон нийтийн байгууллагыг сүүлийн үед иргэний нийгмийн байгууллага гэж бичиж, ярих болжээ. Үндсэн хуулийн оршилд заасан иргэний нийгэм гэдэг ойлголт илүү өргөн утга агуулгатай юм.

Улс төрийн нам бол засгийн эрхийг эзэмдэх, эс бөгөөс түүнд нөлөөлөх зорилготой, нийгэм, улс төрийн амьдралын янз бүрийн салбар, хүрээнд нийтлэг ашиг

сонирхлоороо нэгдсэн зохион байгуулалттай, тогтвортой нийгмийн хэсэг юм.

Улс төрийн нам нь эртний Грек, Ромд үүссэн гэж үздэг. Гэхдээ улс төрийн нам өнөөгийн утга агуулгаараа XIX зууны эхээр үүссэн гэж үздэг байна. Энэ нь юуны өмнө сонгуулийн эрх зүй ардчилагдаж, сонгуулийн эрх бүх нийтийн шинжтэй болсонтой холбоотой. Анх баруун Европт улс төрийн нэгдэл нь клуб хэлбэртэй байжээ. Орчин үеийн улс төрийн нам 1830 онд АНУ-д, 1861 онд Англид үүсэн байгуулагдсан гэж үздэг байна. Ийнхүү улс төрийн нам байгуулагдаж эхэлсэн нь парламентын сонгууль, сонгуулийн эрх зүйг ардчилахтай холбоотой байсан гэж үздэг. Одоогийн АНУ-ын хоёр гол том нам 1930-аад оны эхээр байгуулагджээ.

XVIII зууны эхээр АНУ-ын зарим мужид цуглаан (лат. Causus-аяга, тэмцээн) бий болж, ямар нэгэн асуудлаар ижил үзэл бодолтой, тэгээд ч өөрсдийн төлөөлөгчийг сонгох, ямар нэгэн ажил, албанд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг байжээ. Иймэрхүү цуглаан, цугларалт, нэгдлээс уламжлан байнгын гишүүнгүй улс төрийн намууд бий болжээ. Ингэхдээ тухайн намын төлөө санал өгсөн хүмүүсийг гишүүн гэж тооцдог байж. Мөн XIX зууны үеэс АНУ-д сунгааны өвөрмөц тогтолцоо бий болжээ. Сунгаа буюу урьдчилсан сонгууль (англи *primary*-урьдчилсан, анхдагч) нь нэр дэвшигчдийг шууд сонгох тогтолцоо юм. Улс төрийн намын үүсэл, хөгжилд өөр чиглэл бий болов. Янз бүрийн үзэл бодол, ашиг сонирхол бүхий хүмүүсийн бүлэг, нэгдэл үүсч эхлэв. Тухайлбал, үйлдвэрчний эвлэлийн суурь дээр 1900 онд Англид Хөдөлмөрийн (Лейборист) нам байгуулагджээ. Скандинавын орнуудад (Дани, Норвеги, Швед, Финланд) тариалан эрхлэгч хоршооллын суурь дээр нам үүсчээ. Өөрөөр хэлбэл, намууд парламентаас гадуур үүсч төлөвшсөн байна. Ажилчны хөдөлгөөнтэй холбогдож шинэ намууд үүсч эхэлжээ. 1875 онд Германд яг ийм угшилтай Социал демократ нам байгуулагдаж, 1877 оны парламентын сонгуульд 19.7%, 1912 онд 34.8%-ийн санал авч байжээ. Клубуудыг халж бий болсон ажилчны намууд илүү сахилга, дэг журамтай, зохион байгуулалтын бүтэц нь илүү тодорхой болсон байна. Барууны ардчиллын өлгий болсон Францад III Бүгд найрамдах улсын үед Бүгд найрамдах, Монархист хоёр нам бий болжээ. Францад 1901 онд Радикал нам байгуулагдаж, парламентад олон суудал авах болжээ. Дэлхийн I дайны дараа Францын Коммунист нам байгуулагдсан байна.

Бүхэлд нь дүгнэвэл XX зуун гадаад орнуудад улс төрийн нам олноороо үүсч байгуулагдсан эрин үе байлаа. Үүний учир нь сонгуулийн эрх зүй ардчилагдаж, хөгжингүй орнуудад нийгмийн олон тулгамдсан асуудал бий болж, нийгмийн амьдралын янз бүрийн салбарт төрийн үүрэг, ач холбогдол нэмэгдсэн, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хурдацтай хөгжиж байгаад оршино.

2.

УЛС ТӨРИЙН НАМЫН ЧИГ ҮҮРЭГ

Чиг үүрэг бол улс төрийн намын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл юм. Улс төрийн намын чухал зорилт бол төрийн эрх мэдлийг авах, түүнчлэн төрийн эрх мэдэлд нөлөөлөхийг эрмэлзэх явдал юм. Энэ бол олон нийтийн байгууллагаас аливаа улс төрийн намын ялгдах гол шинж, шалгуур юм. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэх үүднээс улс төрийн нам сонгуульд оролцдог. Улс төрийн нам хуулийн хүрээнд сонгуулийн кампанит ажил зохион байгуулж, сонгуульд намаасаа нэр дэвшүүлдэг.

Үзэл суртлын үйл ажиллагаа бол улс төрийн намын нэг чухал чиг үүрэг болой. Улс төрийн нам улс төрийн хөтөлбөр боловсруулж, сонгуульд оролцдог. Энэхүү хөтөлбөртөө шийдвэрлэх асуудал, хэрэгжүүлэх арга замыг заасан байдаг. Гэхдээ янз бүрийн хүчин зүйлээс шалтгаалж хөтөлбөрийн заалтууд биелэгдэхгүй байх, хоосон амлалт болох нь цөөнгүй. Нөгөө талаас сөрөг хүчний намууд өөрсдийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ парламентад хуулийн төсөл хэлэлцэхэд байр сууриа илэрхийлэх, улс төр, эдийн засгийн шинжтэй кампанит ажил зохион байгуулах арга хэмжээ авдаг байна.

Улс төрийн намын бас нэг чиг үүрэг нь хүн амыг соён гэгээрүүлэх, байр сууриа сонгогчдод тайлбарлан таниулах, үзэл санаагаа зөвтгөх, бусад намыг, ялангуяа засгийн эрхэнд байгаа намыг шүүмжлэхэд чиглэгддэг байна.

Улс төрийн намын нэг чиг үүрэг нь намын сахилгын механизмаар дамжуулан гишүүдийнхээ үйл ажиллагааг уялдуулан зохицуулах явдал юм. Ялангуяа энэ чиг үүрэг нь парламентад хэлэлцэж байгаа асуудлаар намын бүлэг нэгдмэл нэг хүчин болж байдгаар илэрдэг.

Парламентын бүлгийн гишүүдийн сахилга ямар байх нь сонгуулийн тогтолцооноос багагүй хамааралтай. Тухайлбал, хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцооны үед нэр дэвшигч

өөрийн намын удирдлагаас үлэмж хамааралтай байна. Олныг төлөөлөх тогтолцооны үед нэр дэвшигчийн намын хамаарал арай бага байна. Гэхдээ аль ч тохиолдолд намын дэмжлэггүйгээр амжилт олоход амаргүй.

3.

УЛС ТӨРИЙН НАМЫН АНГИЛАЛ

Улс төрийн намууд үндсэн зорилго, нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхлыг хэрхэн тусгаж илэрхийлж байгаа болон зохион байгуулалтын бүтэц, гишүүдийн тоогоор харилцан адилгүй байдаг. Ямар хүчин зүйлийг үндэслэн намууд хоорондоо ялгарч буйг нь үндэслэн ангилдаг. Намуудыг зүүний, барууны, шашны, албан тушаалтны, олон түмний гэх зэргээр ангилдаг.

Улс төрийн намуудыг хооронд нь зааглан ялгах чухал шалгуур бол нийгмийн бүлгүүдийн тус тусын ашиг сонирхол юм. Энэхүү шалгуурыг тодорхойлох гол үндэслэл нь улс төрийн намын зорилго болно. Энэ шинжээр нь намыг хөрөнгөтний, хөдөлмөрчдийн (урьд нь ажилчин нам хэмээн нэрлэдэг байсан), дунд давхаргын, сэхээтний, хөдөө аж ахуйн салбарын ашиг сонирхлыг илэрхийлсэн нам гэж ангилдаг байна. Сүүлийн жилүүдэд нийгмийн "хатуу" тодорхой бүлгийг тусгайлан дэмжихгүй намууд үүсэн төлөвшиж байна. Үүнд юуны өмнө байгаль хамгаалах чиглэл бүхий "ногоон" намыг дурдаж болно. Улс төрийн хөтөлбөртөө шашны үнэт зүйлийг тунхагласан, тухайлбал католик урсгалын (ХБНГУ-ын Христосын ардчилсан холбоо, Италийн Христосын ардчилсан нам зэрэг) нам нь үүнд хамаарагдаж байна.

Намын ангилалын үндэс нь түүний хүрэхээр тэмүүлж буй зорилго. Энэ үндэслэлээр томоохон хөрөнгөтнүүдийн ашиг сонирхлыг илэрхийлдэг Английн консерватив нам; жижиг, дунд хөрөнгөтний ашиг сонирхлыг илэрхийлдэг Английн либерал намыг онцлон хэлж болох юм. Либерал намын хөтөлбөр, үйл



ажиллагааны үндэс нь өмчлөгчийн эрх чөлөөг бататгах, эдийн засгийн хүрээнд төрийн оролцоог багасгах зарчим болой.

Хөдөлмөрчдийн нам нь коммунист, социалист гэж ангилагддаг байна. Коммунист намын зорилго нь хувийн өмчийг үгүйсгэж, эдийн засаг, нийгмийн амьдралд төрийн оролцоо нөлөөг нэмэгдүүлэх явдал юм. Сүүлийн жилүүдэд коммунист намуудын нөлөө буурч, өөр үзэл, чиглэл бүхий намуудын үзэл баримтлал, бодлогоо авч хэрэгжүүлэх нь нэмэгдэж байна.

XX зууны 3 дугаар хагасаас үүссэн социалист (социал демократ) намууд ялангуяа баруун Европт нөлөө нь нэмэгдэж, ажилчдыг хамгаалах, холимог эдийн засгийг хөхиүлэн дэмжих, нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх, нийгэмшлийн төрийг байгуулах чиглэлээр үйл ажиллагаагаа өрнүүлж байна. Ажлын байрыг бий болгох, нийгэм, эдийн засгийн салбарт эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах нь социал демократ намын чухал бодлого юм.

Бүс нутгийн шинжтэй, тэрхүү бүс, нутаг дэвсгэрийн иргэдийн төлөө

байгуулагдсан улс төрийн намууд бий. Англид л гэхэд Шотландын, Ирландын болон Валлийн үндсэрхэг нам байна. Испанид Баскийн болон Каталаны үндсэрхэг нам байдаг. Тодорхой хэсэг хүн ам, үндэстний эрх ашгийг хамгаалсан нам ч байна. Үүний тод жишээ нь гэвэл Финланд улсад Шведын нам, Дани улсад Германы намыг нэрлэж болох юм. Янз бүрийн алаг цоог, өөр өөр зорилго бүхий хэт барууны радикал намууд үндсэрхэг, фашист чиглэлийн үйл ажиллагаа явуулж байна.

4.

НАМЫН ТОГТОЛЦОО

Намын тогтолцоог ангилах үндэс нь намын тоо, түүний хэмжээ далайц юм. Намын тоонд түүхэн нөхцөл байдал, үндэстний бүрэлдэхүүн, хүн амын шашны хамаарал зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг байна. Түүнчлэн сонгуулийн тогтолцоо ч бас нөлөөлдөг. Нам нь тогтолцооны хувьд олон намын, хоёр намын, нэг намын гэж ялгагддаг байна. Намын тогтолцооны үндсэн үзүүлэлт нь төрийн байгууллагуудыг, юуны өмнө Засгийн газрыг эмхлэн байгуулахад оролцох боломж, түүнчлэн улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх боломж юм.

Улс төрийн намыг хэмжээний хувьд том, дунд, жижиг гэж ангилах боловч тодорхой ангилах шалгуур бараг үгүй. Ингэж ангилах гол шалгуур нь гишүүдийн тоо байна. Өөр нэг шалгуур нь сонгуульд сонгогчдын санал авсан тоо. Энд мөн ерөнхийлөгчийн болон холимог бүгд найрамдах улсад шууд сонгуулиар авсан тоо хамаарна. Үүний зэрэгцээ парламент дахь намын бүлгийн тоо, хэмжээ нь сонгогчдын дэмжлэгийг бүрэн илэрхийлж чадахгүй бөгөөд үүний учир шалтгаан нь сонгуулийн тогтолцооны дагуу олж

авсан мандатын тоотой холбоотой. Парламентын бүлгийн тоо, хэмжээ нь хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцооны үед нийгэмд бодитой нөлөөлж байдаг. Харин олныг төлөөлөх сонгуулийн тогтолцоонд намын тоо, түүний нөлөөлөл нь парламентын намын бүлгийн бүрэлдэхүүний тоотой тэр бүр шууд хамааралтай байдаггүй.

Хэд, хэдэн нам эвсэл байгуулж, Засгийн газрыг бүрдүүлж байгаа орнуудад олон намын тогтолцоо оршиж байдаг. Олон намын тогтолцооны үед нэг том нам бусад жижиг, дунд намаа давамгайлж байдаг бол өөр нэг тохиолдолд адил хүчтэй намууд засгийн эрхэнд гарсан байдаг аж. Энэ тохиолдолд намын удирдлагууд зөвшилцож тохиролцох, Засгийн газрын суудлыг "наймаалцах" нь цөөнгүй.

Хоёр намын тогтолцооны үед олон жижиг, дунд нам байх боловч тэрхүү хоёр том нам нь л үндсэндээ Засгийн газрыг эмхлэн байгуулахад оролцож байна. Гэхдээ жижиг намууд Засгийн газрын бүрэлдэхүүнд багтаж, сонгуулийн байгууллагад шийдвэрлэх нөлөөгүй ч бусад нам, бүлгйн саналд бас ч хувь нэмэр болж байдаг. Ийм намыг дагалт нам (гер. Schamnier, фр. charnière-хавсарга, нэгдэх газар) гэдэг байна. Жишээ гэвэл 1998 онд Бундестагийн (ХБНГУ) сонгуульд ногоон нам 6.5%-ийн санал авч Социал демократ намтай хамт Засгийн газрыг бүрдүүлж байжээ.

Нэг намын тогтолцоо голчлон дарангуйлагч гэгддэг улсад байна. Кубын 1976 оны Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд Кубын коммунист нам нь социализм байгуулах эрхэм дээд зорилго бүхий төр, нийгмийг удирдах дээд хүч болох тухай заажээ.

Улс төрийн намын тогтолцоог харахад олон намын болон хоёр намын тогтолцоо нь хүн амын улс төрийн хүсэл эрмэлзлэлийг илүү илэрхийлж байна. Гэхдээ аль тогтолцоо нь "илүү" болохыг шууд батлах боломжгүй юм.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын гол үзэл санаа нь улс төрийн намыг бодлогын институт болж төлөвшиүүлэх, дотоод ардчиллыг дэмжиж бэхжүүлэх, намын санхүүжилтийн ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн. Тус хуулийн хэрэгжилтээс онцолж байна.


УЛС ТӨРИЙН НАМЫН

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 нам үйл ажиллагаа явуулж байна. Улс төрийн намын тухай хуулийн 9.5, 9.6-д заасны дагуу нам албан ёсоор нийтэд зарласан цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягтай бол тэдгээрийг Харилцаа холбооны зохицуулах хороо, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлэх, мөн хуульд заасан дараах 16 төрлийн баримт бичиг, мэдээллийг ил тод, байршуулж, тухай бүр шинэчлэх үүрэг хүлээсэн.

УЛС ТӨРИЙН НАМЫН ЦАХИМ ХУУДАС

1. намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;
2. намын дүрэм;
3. намын хөтөлбөр;
4. намын сонгуулийн мөрийн хөтөлбөр;
5. намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа газрын хаяг;
6. намын даргын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
7. намын ерөнхий нарийн бичгийн дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
8. намын удирдах дээд, төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын дарга, гишүүний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
9. намын утасны дугаар, цахим шуудангийн хаяг;
10. намын гишүүний тоо;
11. намын болон харьяа байгууллагын санхүүгийн тайлан;



12. намын үйл ажиллагааны товч тайлан;
13. нам аймаг, сум, нийслэл, дүүрэгт салбар нэгжтэй бол тэдгээрийн нэгжийн даргын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
14. намын бүтэц, зохион байгуулалт;
15. намын үйл ажиллагааны мэдээлэл;
16. бусад мэдээлэл.

Сонгуулийн ерөнхий хороо цахим хуудсандаа Улс төрийн намын тухай хуулийн 9.10-д заасан намын нээлттэй мэдээллийг байршуулж, тухай бүр шинэчилж нийтэд мэдээлэх үүрэг хүлээсэн. Энэ үүргийнхээ дагуу Хорооны цахим хуудаст "Намын нээлттэй мэдээлэл" цэс шинээр үүсгэж, Монгол Улсын дээд шүүхэд

бүртгэлтэй 37 намын баримт бичиг, нээлттэй мэдээллийг байршуулан, уг мэдээллийг шинэчлэхэд тухайн намын нээлттэй мэдээлэл хариуцсан ажилтантай хамтран ажиллаж байна.

МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ, ШИНЭЧЛЭХ:

Улс төрийн нам нь хуульд заасан нээлттэй мэдээлэл, баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд нийлүүлэх, өөрчлөлт оруулснаас хойш 30 хоногийн дотор хүргүүлж цахим хуудас дахь мэдээллийг шинэчлэх үүргийг хүлээнэ. Нам нээлттэй мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд нийлүүлээгүй тохиолдолд зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээхээр хуульчилсан.

УЛС ТӨРИЙН НАМД ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ШУУД БУС ДЭМЖЛЭГ

Улс төрийн намын тухай хуульд зааснаар УИХ-ын ээлжит болон ээлжит бус сонгуульд оролцож, нийт сонгогчдын нэг ба түүнээс дээш хувийн дэмжлэг авсан нам төрийн санхүүжилт авна. Төрийн санхүүжилт нь "Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг" болон "төрөөс үзүүлэх шууд бус дэмжлэг" гэсэн хоёр төрөлтэй байна.

Нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан нам төрөөс үзүүлэх дараах хоёр төрлийн шууд бус дэмжлэгийг авна.

1. Уулзалтын танхим, хурлын заалыг жилд нэг удаа үнэ төлбөргүй ашиглах эрхтэй. Уг танхимыг нам удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд, дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор хэрэглэх боломжтой.
2. Олон нийтийн радио, телевизээр улирал тутам 30 минут нэвтрүүлэг хийх дэмжлэг. Нам энэхүү нэвтрүүлгийг намын хөтөлбөр, үйл ажиллагаагаа тайлбарлан танилцуулах зорилгоор ашиглана.

Дэмжлэгийн зорилго нь Улс төрийн намыг Улсын хэмжээний бодлогын нам болгон төлөвшүүлэх, намын дотоод ардчилал болон ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилготой.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр Монгол Ардын нам, Ардчилсан нам, Монголын ногоон нам, Монгол үндэсний ардчилсан нам, Иргэний зориг ногоон нам, ШИНЭ нам, Монголын уламжлалын нэгдсэн нам,

ХҮН нам, Үнэн ба Зөв нам шууд бус дэмжлэг авах эрхтэй болсон.

УУЛЗАЛТЫН ТАНХИМ, ХУРЛЫН ЗААЛ

Улс төрийн намын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т "намын удирдах дээд байгууллагыг хуралдуулах, гишүүд, дэмжигчидтэй хийх уулзалт, хурал зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимыг жилд нэг удаа үнэ төлбөргүй ашиглах" эрхтэй.

Төрийн болон төрийн өмчийн

оролцоотой хуулийн этгээдийн уулзалтын танхим, хурлын заал, бусад танхимаа үнэ төлбөргүй ашиглуулах үүрэгтэй.

Сонгуулийн төв байгууллагаас улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монголын хүүхдийн ордон, Нийслэлийн Соёлын төв өргөөтэй хамтран хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрөөс шууд бус дэмжлэг авах эрх бүхий намууд /9 нам/ сонгуулийн бус жилд нэг удаа хурлын заал, танхим үнэ төлбөргүй ашиглах эрхтэй. Энэхүү шууд бус дэмжлэгийн хүрээнд Иргэний зориг ногоон нам "НАМЫН ХИ ИХ ХУРАЛ"-аа 2025 оны 3 дугаар сарын 9-ний өдөр



Монголын хүүхдийн ордонд зохион байгууллаа. Тус намын их хуралд нийт 450 орчим намын төлөөлөгч оролцсон байна.

Хоёр. Тус хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2-т "намын хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх нэвтрүүлгийг олон нийтийн радио, телевизээс гаргасан хуваарийн дагуу 30 минутаар улирал тутам үнэ төлбөргүй нэвтрүүлэх" гэж хуульчилсан.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооноос Монголын үндэсний олон нийтийн

радио болон Монголын Үндэсний олон нийтийн телевизтэй тус тус хамтран ажиллаж байна.

Шууд бус дэмжлэг авах эрх бүхий 9 намаас 2025 оны 1 дүгээр улиралд **Монгол үндэсний ардчилсан намаас** Монголын Үндэсний Олон нийтийн Радиоогоор намын тухай танилцуулга, лого бэлгэ тэмдгийн утга учир, бэлгэдлийн талаар болон намын эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбоотойгоор намын шинэчлэлийн талаар мэдээллийг 2025 оны 1 дүгээр сарын 15-нд 30 минутын

радиоогийн нэвтрүүлгээр олон нийтэд танилцууллаа.

Иргэний зориг ногоон намаас 2025 оны 3р сарын 10-ны 19:00 цагт намын 25 жилийн ойд зориулсан 30минутын нэвтрүүлгийг Монголын Үндэсний Олон нийтийн телевизээр нийтэд түгээх байдлаар шууд бус дэмжлэг авсан байна.

Улс төрийн намын мэдээлэл,
арга зүйн газар



**УЛС ТӨРИЙН НАМУУДЫН
АНХААРАЛД:**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААС 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН 2 ДУГААР ЗҮЙЛИЙГ "НАМ ӨӨРИЙН ДҮРЭМ, ХӨТӨЛБӨР, ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ТАЙ НИЙЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН ДОТОР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ БӨГӨӨД УГ ӨӨРЧЛӨЛТИЙГ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД 30 ХОНОГИЙН ДОТОР ХҮРГҮҮЛНЭ" ГЭЖ ӨӨРЧЛӨН НАЙРУУЛСАН БАЙНА. ИЙМД УЛС ТӨРИЙН НАМ ӨӨРИЙН ДҮРЭМ, ХӨТӨЛБӨР, ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН ДОТОР УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ИРҮҮЛЭХИЙГ АНХААРНА УУ.



**УЛС ТӨРИЙН
НАМЫН БҮРТГЭЛ
ХӨТЛӨХ ЖУРАМТАЙ
ТАНИЛЦАНА УУ.**





www.supremecourt.mn

УЛС ТӨРИЙН НАМД ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

Н.БУЛГАМАА:

**БҮХ НАМ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГАА ГАРГАХ,
ТАЙЛАН НЬ НИЙТЭД
ИЛ ТОД БАЙХ
ЗОХИЦУУЛАЛТТАЙ**



Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн талаар Сонгуулийн ерөнхий хорооны Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын дарга Н.Булгамаатай ярилцлаа.

-Улс төрийн намын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ын онцлох зохицуулалт нь улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгож, олон нийтийн хяналтад оруулах. Намуудын санхүүгийн тайланг нийтэд мэдээлэх ажил ямар шатандаа байгаа вэ?

-Улс төрийн намууд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2025 оны 2 дугаар сарын 10-ны дотор Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлэхээр Улс төрийн намын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасан. Энэ жилийн тухайд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 улс төрийн намаас 27 нь санхүүгийн жилийн эцсийн тайлангаа хуулийн хугацаанд ирүүллээ.

Хуульд зааснаар намын санхүүгийн тайланд гурван үе шаттай хяналт хэрэгжүүлэх юм. Нэгдүгээрт, аудитын хуулийн этгээд дүгнэлт гаргах ёстой. Энэ жилийн тухайд “Миндуг аудит”

компани дээрх 27 намын санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан. Түүнчлэн Миний Монгол нам “Баталгаат тооцоолол аудит” компаниар дүгнэлт гаргуулсан тайлангаа Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлсэн.

Хоёрдугаарт, Аудитын хуулийн этгээдийн дүгнэлт бүхий санхүүгийн тайланг Сонгуулийн ерөнхий хороо хянаж 4 дүгээр сарын 5-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр хуульчилсан. Хуульд

НАМУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНТАЙ
Сонгуулийн ерөнхий хорооны



www.m-election.mn



цахим хуудаснаас

ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ

заасны дагуу манай байгууллага намуудын санхүүгийн тайланг хянаж Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

Гуравдугаарт, Төрийн аудитын байгууллага төсвийн цаглаврын дагуу аудит хийж, дүгнэлт гаргах юм. Түүнчлэн Төрийн аудитын байгууллага төрөөс намд олгосон санхүүжилт, гүйцэтгэлд гаргасан дүгнэлтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусган тайлагнах юм.

-Тайлан нь нээлттэй байгаа юу?

-Улс төрийн намын тухай хуульд заасан цаг хугацааны цаглаврын дагуу намуудын санхүүгийн тайлангийн хяналтын ажлууд нь үргэлжилж байгаа бөгөөд хараат бус аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан 27 намын санхүүгийн тайлан Сонгуулийн ерөнхий хорооны www.m-election.mn цахим сайтад нээлттэй байршсан.

-Төрөөс санхүүжилт авахгүй намууд тайлан гаргаж өгөх шаардлага байсан уу?


-Улс төрийн намыг бодлогын институт болгон төлөвшүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэх, дотоод ардчиллыг нь дэмжих, намын санхүүжилтийн ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэх нь Улс төрийн намын тухай хуулийн гол үзэл баримтлал. Тийм ч учраас бүх намууд санхүүгийн тайлангаа гаргаж өгөх ёстой. Үйл ажиллагаа явуулаагүй, орлого зарлага хийгээгүй ч Х тайлангаа гаргаж өгөх учиртай. Хоёр жил дараалан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй намыг идэвхгүйд тооцохоор хуульд заасан.

СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА жил бүрийн

IX.15

өдрөөс өмнө

төрийн санхүүжилт авах эрх бүхий нам бүрд төрийн санхүүжилтийн эрх үүсэх **ЖИЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭГ** энэ хуульд заасны дагуу тогтоож, **НИЙТЭД МЭДЭЭЛНЭ**



-Намууд анх удаа санхүүгийн тайлангаа хянуулж байна. Тайлан гаргахдаа нийтлэг алдаа байсан болов уу?

-Хараат бус аудитын хуулийн этгээдэд хяналт хийж байхад анхан шатны баримтууд гаргаж өгөхөд хойрго, удаан байх асуудал байсан. Улс төрийн намын санхүүгийн тайлан Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, "Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайлагнах журам", "Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг

шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх, хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг хангасан эсэхийг 3 үе шаттай хянадаг. Мөн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу гаргасан эсэх, алдаа, зөрчлийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэсэн эсэх, үнэн зөв толилуулсан эсэх зэрэгт үе шат бүрд намуудад нэг бүрчлэн дүгнэлт гаргаж, зөвлөмж өгөх юм. Тэгтэл дээрх журамд заасан маягтуудын дагуу тайлангаа гаргаагүй зэрэг асуудал гарсан. Анхны ажил учраас алдаа дутагдал гарсан даруйд нь заавар, зөвлөмж өгөөд намуудтайгаа хамтраад ажилласан.



-Хуульд заасан шаардлага хангасан долоон намд төрөөс санхүүжилт олгохоор болсон. Сонгуулийн ерөнхий хорооноос өнгөрсөн есдүгээр сард зарласан хэмжээгээр санхүүжилт олгох уу?

-Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө төрийн санхүүжилт авах эрх бүхий нам бүрд төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилийн санхүүжилтийн хэмжээг энэ хуульд заасны дагуу тогтоож, нийтэд мэдээлэх зохицуулалттай. Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар нам, эвсэлд олгож болох төрийн санхүүжилтийн дээд хэмжээг төлөвлөж, тогтоон олон нийтэд ил тод мэдээлсэн.

Улс төрийн намын тухай хуульд нам, эвсэлд төрийн санхүүжилтийг 2 төрлөөр олгохоор заасан.

Үүнд: 1. Жил бүр олгох санхүүжилт:

Хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т "Нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгоно.", 27.5-т "Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг

хангасан намд дараах томъёогоор төрийн санхүүжилтийг жил бүр олгоно:" гэж заасан.

$$H = /C1 \times T1/ + /C2 \times T2/$$

"H" гэж нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн дэмжлэг авсан намд хуваарилах нийт санхүүжилтийг;

"C1" гэж Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналын тоог;

"C2" гэж Улсын Их Хуралд тухайн намын авсан суудлын тоог;

"T1" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.5 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг;

"T2" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг.

2. Дөрвөн жилд нэг удаа олгох санхүүжилт:

Хуулийн 27 дугаар зүйлийн 27.7-т "Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн

тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно." гэж заасан.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан 7 нам, эвсэл бий.

-Дээрх долоон нам санхүүжилтээ хэзээ авах вэ?

-Дээр дурдсан 3 үе шаттай хяналтыг хэрэгжүүлсний дараа намуудад санхүүжилт олгоно. 2025 оны тавдугаар сард санхүүжилт олгохоор төлөвлөн ажиллаж байна.

-Санхүүгийн тайланг хянасны дараа намуудын авах санхүүжилтийн хэмжээ өөрчлөгдөх үү?

-Санхүүгийн тайлангийн хяналтын ажил дуусаагүй учраас тодорхой хэмжээ хэлэхэд эрт байна. Аудитын хяналт дууссаны дараа тодорхой болно.

Нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан нам, эвсэлд олгох нийт санхүүжилтийн хэмжээ (төгрөгөөр)

№	Нам, эвслийн нэр	Хуулийн 27.5-т заасны дагуу /санхүүжилт олгох томъёогоор	Хуулийн 27.7-т заасны дагуу /квот болон ХБИ	Төрийн санхүүжилт олгох нийт хэмжээ
A	Б	1	2	3
1	МОНГОЛ АРДЫН НАМ	2,803,290,600	16,500,000	2,819,790,600
2	АРДЧИЛСАН НАМ	2,140,069,800	33,000,000	2,173,069,800
3	ХҮН НАМ	630,666,300	363,000,000	993,666,300
4	ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ	314,146,800	132,000,000	446,146,800
5	ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ	306,919,800	148,500,000	455,419,800
6	"ШИНЭ НЭГДСЭН ЭВСЭЛ" (МУНН-ШН)	229,950,600	82,500,000	312,450,600
7	ҮНЭН БА ЗӨВ НАМ	134,583,900	115,500,000	250,083,900
Нийт		6,559,627,800	891,000,000	7,450,627,800

Нам, эвсэлд олгож болох төрийн санхүүжилтийн дээд хэмжээ

МОНГОЛ УЛС АЗИ ТИВЭЭС АНХ УДАА НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ (ОГР)-ИЙН УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ СОРИЛТОД НЭГДЛЭЭ

Нээлттэй Засгийн түншлэл (ОГР)-ээс 2024 оноос шинээр хэрэгжүүлж эхэлсэн Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах Сорилтод Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо Азийн орнуудаас анх удаа нэгдсэн. Тус түншлэлийн хяналтын хороо Сонгуулийн ерөнхий хорооны санаачилгыг хянан үзэж, Ази тивээс Сорилтод нэгдсэн анхны улс хэмээн батлан, 2025 оны хоёрдугаар сарын 5-7-ны өдрүүдэд Филлиппин улсад зохион байгуулсан Ази, Номхон далайн гишүүн орнуудын Бүсийн чуулганы үеэр гэрчилгээ олгосон юм.

Ази, Номхон далайн гишүүн орнуудын Бүсийн чуулганд Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ оролцож улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлж байгаа шинэлэг ажил, зорилт, төлөвлөгөөгөө танилцуулсан.

Монгол Улс Нээлттэй Засгийн түншлэлийн Сорилтод нэгдсэнээр улс төрийн намын санхүүжилтийн ил тод



байдлыг хангахад олон улсын өмнө хариуцлага хүлээж байгааг чуулганд оролцогчид болон Сонгуулийн ерөнхий хорооны төлөөлөл онцолсон юм.





НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ (OPEN GOVERNMENT PARTNERSHIP)-ИЙН “УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ” СОРИЛТОД НЭГДЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Нээлттэй засаглалын түншлэл (OGP) гэж юу вэ?

Нээлттэй засаглалын түншлэл (OGP – Open Government Partnership) нь засгийн газруудын ил тод, хариуцлагатай, иргэдэд нээлттэй байх зарчмыг дэмжих зорилготой олон улсын санаачилга юм. Энэхүү түншлэлийг 2011 онд АНУ, Их Британи, Бразил, Индонез, Мексик, Норвеги, Филиппин, Өмнөд Африк зэрэг 8 улс хамтран байгуулсан.

OGP-ийн үндсэн зорилго:

- Засгийн газрын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах
- Иргэний нийгмийн оролцоог

нэмэгдүүлэх

- Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, авлигатай тэмцэх
- Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах

Монгол Улс 2013 онд OGP-ийн гишүүнээр элсэн орж, нээлттэй засаглал, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр олон ажил хэрэгжүүлж байна.

“Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах” сорилтод нэгдэхийн ач холбогдол”

OGP нь 2021 онд улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах

сорилт”-ыг эхлүүлсэн.

Энэхүү сорилтод нэгдэхийн ач холбогдол:

- Намуудын санхүүжилтийг ил тод болгох – Улс төрийн намуудын орлого, зарлагыг ил тод болгох нь иргэд, сонгогчдын итгэлийг нэмэгдүүлнэ.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх – Санхүүжилтийн эх үүсвэрийг ил тод болгосноор улс төр дэх хэт нөлөөллийг бууруулж, шударга өрсөлдөөнийг хангана.
- Олон улсын жишигт нийцүүлэх – Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах нь олон

улсын сайн туршлагад нийцэж, ардчиллыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна.

4. Сонгогчдын мэдээлэлтэй байх боломжийг нэмэгдүүлэх – Иргэд сонгуулийн өмнө намуудын санхүүжилтийн талаар мэдээлэлтэй болж, илүү хариуцлагатай сонголт хийх нөхцөл бүрдэнэ.
5. Олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох – OGP-ийн гишүүн орнуудтай хамтран ажиллах, сайн туршлага солилцох боломжийг олгоно.

"Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах" сорилт ба Монгол Улс

1. Сорилтын тухай

"Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах" сорилт нь 2021 онд Нээлттэй засаглалын түншлэл (OGP)-ээс санаачилсан бөгөөд улс орнуудын улс төрийн нам, сонгуулийн

санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилготой. Энэ нь авлигыг бууруулах, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, ардчиллыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын санаачилга юм.

Сорилт нь дараах үндсэн чиглэлүүдийг хамардаг:

- » Улс төрийн санхүүжилтийн мэдээллийг ил тод, хялбар ойлгомжтой болгох
- » Намуудын орлого, зарлагын эх үүсвэрийг хянах, хяналтын механизм бий болгох
- » Сонгуулийн санхүүжилтийг хянах байгууллагын хараат бус байдлыг нэмэгдүүлэх
- » Мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих

2. Монгол Улс ба улс төрийн санхүүжилтийн ил тод байдал

Улс төр дэх мөнгөний нөлөөллийг багасгах, иргэний улс төрийн эрхийг чөлөөтэй эдлүүлэхэд улс төрийн намын санхүүжилтийн ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх нь хамгийн чухал юм. Иймд манай улсын хувьд улс төрийн намын санхүүжилтийн ил


тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн өөрчлөлтөд хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Монгол Улсын хувьд 2019 онд Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгоход чиглэсэн томоохон өөрчлөлтийг хэрэгжүүлэх эрх зүйн орчны үндэс тавигдсан. Үүний дагуу Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 онд батлагдан хэрэгжиж байна.

Энэхүү хуулиар улс төрийн намыг илүү хариуцлагатай, бодлогын нам болгож төлөвшүүлэх, мөн санхүүжилт нь ил тод, олон нийтийн хяналтад байх зэрэг дэвшилттэй зохицуулалтуудыг хуульчилсан. Одоо бидний хувьд энэ хуулийг бүрэн хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байгаа. Тухайлбал Сонгуулийн ерөнхий хорооны хувьд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, түүнд хяналт тавих, мөн олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлж ажиллах нь чухал юм.

Уг хуульд зааснаар улс төрийн





намын санхүүжилтийн ил тод байдал нь улс төрийн намын санхүүгийн тайлангийн ил тод байдал, мөн тайлан нь орлого, зарлага, хөрөнгө гэсэн үндсэн 3 ангилалд хуваан, нийт 26 төрлийн санхүүгийн мэдээллийг бүртгэж, тайлагнахаар хуульчилсан. Харин эдгээр олон үзүүлэлтээр уламжлалт аргаар буюу цаасан суурьтай хөтлөлтийг явуулах нь улс төрийн намын санхүүжилтийг бүрэн хэмжээнд хяналт тавьж, олон нийтэд ил тод мэдээлэхэд хүндрэлтэй юм.

Иймд Сонгуулийн ерөнхий хороо

нь улс төрийн намын санхүүгийн мэдээллийг бүрэн гүйцэт хөтөлж, олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилгоор улс төрийн намын санхүү бүртгэлийн нэгдсэн цахим флатформыг хөгжүүлэн ашиглах нь илүү үр дүнтэй бөгөөд хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах боломж бүрдэх талаар улс төрийн намуудтай уулзаж нэгдсэн ойлголцолд хүрээд байгаа билээ.

Чөлөөт, шударга сонгуулийн аргаар сонгогдож, Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэгч, бодлогын институт

болохын тулд улс төрийн намын зохион байгуулалт, үйл ажиллагаа болон намын санхүүжилт нь хуулийн дагуу, шударгаар бүрдсэн байх, мөн санхүүжилт нь ил тод, олон нийтийн хяналтад байхад энэхүү өөрчлөлт чухал ач холбогдолтой.

Сонгуулийн ерөнхий хороо нь хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахын тулд дээрх шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоо баталгаажуулан Нээлттэй засгийн түншлэлийн Сорилтод нэгдэж, 2025 оны 02 дугаар сард улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах цахим систем хөгжүүлэх амлалтаа албан ёсоор танилцуулсан. Тодруулж хэлбэл, Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах Сорилтод Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо Азийн орнуудаас анх удаа нэгдсэн. Монгол Улсад улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах нь ардчиллын суурь зарчмуудыг хамгаалах, авлигаас урьдчилан сэргийлэх, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. OGP-ийн "Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах" сорилтод нэгдсэнээр улс төрийн тогтолцоог илүү хариуцлагатай, нээлттэй болгох алхмыг хийх боломжтой юм.





УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ЦАХИМ ШИЙДЛҮҮДИЙН ТУРШЛАГЫГ ХЭЛЭЛЦЭВ

Улс төрийн намын санхүүжилтийн нээлттэй, ил тод байдлыг хангах олон нийтийн хяналтад оруулах зорилгоо хэрэгжүүлэх үүднээс Сонгуулийн ерөнхий хороо Нээлттэй засгийн түншлэл, Нээлттэй нийгэм форум, Транспарэнси Интэрнэшнл олон улсын байгууллага, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагатай хамтран "Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор улс төрийн намын санхүүжилтийн тайлангийн цахим системийн шаардлагыг тодорхойлох олон улсын туршлага" семинарыг 2025 оны 4 дүгээр сарын 8-9-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа.

Улс төрийн намын санхүүжилтийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн хяналтад оруулах зорилгоор цахим систем нэвтрүүлэхэд олон улсын туршлага судлах, хэрэглэгчид

хэрэгцээгээ тодорхойлж, төсөөлөх зорилготой уг семинарт хамтран зохион байгуулагч олон улсын байгууллагуудаас гадна Сонгуулийн тогтолцооны олон улсын сан (IFES), Армени улсын Авлигаас сэргийлэх комисс, Английн Бристолийн Их Сургууль, НҮБ-ын Хөгжлийн

хөтөлбөрийн төслийн зөвлөх болон улс төрийн намууд, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, Бодлогод залуусын хяналт төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцсон

Семинарын эхний өдөр улс төрийн



намуудын санхүүжилтийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудал болон Латви, Армени, Англи зэрэг олон улсын туршлагыг хэлэлцсэн. Улс төрийн намын санхүүжилтийг тайлагнах системийг хөгжүүлэхдээ улс төрийн намууд мэдээллээ оруулахад хялбар, төрийн байгууллагууд мэдээлэл солилцох боломжтой байхаас гадна олон нийтэд мэдээллийг төрөл бүрээр ангилж харуулах, сонирхсон датагаа татаж авах шийдэлтэй байх шаардлагатайг олон улсын мэргэжилтнүүд өөрсдийн улсын туршлага дээрээ тулгуурлан зөвлөсөн. Мөн систем хувь хүний нууцыг хамгаалсан, аюулгүй байдлыг бүрэн хангасан байх шаардлагатайг оролцогчид онцолж байсан.

Улс төрийн намын санхүүжилтийн тайланг цахим системээр авч, дүн шинжилгээ хийн нийтэд мэдээлж байгаа улс орнуудын туршлагын талаарх мэдээлэл солилцсон оролцогчид семинарын хоёр дахь өдөр



хэрэглэгчдийн бүлэгт хуваагдаж цахим системийн хэрэгцээг тодорхойллоо. Түүнчлэн Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт хийж байгаа Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт хүний эрхийн

алба (АИХЭА)-ны төлөөлөгчид Урьдчилсан зөвлөмжөө семинарын үеэр танилцуулсан юм. Урьдчилсан зөвлөмжийг "Сонгуулийн боловсрол" сэтгүүлийн дараагийн дугаарт нийтэлнэ.





АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН

СОНГУУЛЬ-2025

FREE & FAIR

election



2025.06.22

www.m-election.mn

Монгол Улсын Үндсэн хуулиас...

» Арван зургадугаар зүйл.

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 9/шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;

» Тавин есдүгээр зүйл.

3.Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.

“НӨХӨН СОНГУУЛЬ” ГЭЖ ЮУ ВЭ?

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах сонгууль юм. Өөрөөр хэлбэл, ээлжит сонгуулийн дараа сонгосон төлөөлөгчийн тань бүрэн эрх хуульд заасан үндэслэлээр дуусгавар болсон бол заавал нөхөх нь ардчиллын зарчим. Ингэхдээ Хурлын Төлөөлөгчийн суудал эзгүйрсэн тойрог, мандатад л нөхөн сонгууль явуулах хуультай.

Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрх дараах үндэслэлээр хугацаанаас өмнө дуусгавар болно.

- » нас барсан;
- » хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар

чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;

- » гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан;
- » тухайн орон нутгаас шилжсэн;
- » төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон;
- » төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашигласан;
- » өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх;
- » Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрмийг удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн;
- » Аймаг, нийслэл, сум, дүүргийн

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан үндэслэлээр төлөөлөгчөөр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр хүчингүй болсон.

- » Нөхөн сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа орон гарсан төлөөлөгчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийг жил бүрийн 6 дугаар сарын гурав дахь долоо хоногийн ням гараг (2025.06.22)-т улс даяар нэгдсэн журмаар явуулна.

Орон нутгийн Хурлын сонгуулийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал товлон зарладаг.

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНД ЯВАГДАХ НӨХӨН СОНГУУЛЬ



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНД ЯВАГДАХ НӨХӨН СОНГУУЛЬ

№	Аймаг	№	Сум	Төлөөлөгчийн тоо	Бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа төлөөлөгчийн тоо	Нөхөн сонгууль явагдах мандатын тоо
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал						
1	Баянхонгор	1	Баянлиг	35	34	1
2	Дархан-Уул	2	Шарын Гол	41	40	1
Аймгийн дүн				76	74	2
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал						
1	Баян-Өлгий	1	Ногооннуур	25	24	1
2	Булган	1	Баян-Агт	21	20	1
		2	Бугат	21	20	1
		3	Бүрэгхангай	21	20	1
		4	Гурван Булаг	21	20	1
		5	Дашинчилэн	21	20	1
		6	Орхон	21	20	1
		7	Рашаант	21	20	1
		8	Сайхан	21	20	1
		9	Хишиг-Өндөр	21	20	1
		10	Хутаг-Өндөр	21	19	2
3	Говь-Алтай	1	Бугат	21	20	1
		2	Эрдэнэ	21	20	1
4	Говьсүмбэр	1	Шивээговь	21	20	1
5	Дархан-Уул	1	Шарын Гол	25	23	2
6	Дорноговь	1	Айраг	21	20	1
		2	Дэлгэрэх	15	14	1
		3	Сайхандулаан	15	14	1

7	Дорнод	1	Баяндун	21	19	2
		2	Хөлөнбуйр	15	14	1
8	Дундговь	1	Адаацаг	21	20	1
		2	Сайхан-Овоо	21	20	1
		3	Өлзийт	21	20	1
9	Орхон	1	Баян-Өндөр	29	28	1
10	Өвөрхангай	1	Нарийнтээл	21	20	1
11	Өмнөговь	1	Ноён	15	14	1
12	Сүхбаатар	1	Халзан	15	14	1
13	Сэлэнгэ	1	Алтанбулаг	21	19	2
		2	Баруунбүрэн	21	20	1
		3	Жавхлант	21	20	1
		4	Орхонтуул	21	19	2
		5	Сайхан	29	26	3
		6	Сүхбаатар	29	28	1
		7	Шаамар	21	20	1
14	Төв	1	Аргалант	15	14	1
		2	Батсүмбэр	25	24	1
		3	Жаргалант	25	23	2
		4	Заамар	25	24	1
		5	Лүн	21	20	1
		6	Мөнгөнморьт	21	20	1
		7	Өндөрширээт	15	14	1
		8	Сэргэлэн	21	20	1
		9	Угтаалцайдам	21	20	1
		10	Эрдэнэсант	21	19	2
		11	Эрдэнэ	21	20	1
15	Увс	1	Баруунтуруун	21	20	1
16	Ховд	1	Дарви	21	20	1
		2	Манхан	21	20	1
		3	Мянгад	21	20	1
17	Хөвсгөл	1	Алаг-Эрдэнэ	25	24	1
		2	Ханх	21	20	1
		3	Цагаан-Үүр	21	20	1
18	Хэнтий	1	Батноров	25	24	1
		2	Батширээт	21	20	1
		3	Бор-Өндөр	29	27	2
		4	Дархан	21	20	1
		5	Дэлгэрхаан	21	20	1
		6	Норовлин	21	20	1
Сумын дүн			1236	1168	68	
Улсын дүн			1312	1242	70	

УИХМН
СУДАЛГААНЫ САН

IV.13

өдрөөс өмнө

Аймаг, нийслэлийн
СОНГУУЛИЙН ХОРООГ дарга,
нарийн бичгийн дарга болон

5-7

ГИШҮҮНИЙ

бүрэлдэхүүнтэй байгуулж,
нийтэд мэдээлнэ.



IV.23

өдрөөс өмнө

СУМ, ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН
ХОРООГ дарга, нарийн бичгийн
дарга болон

3-5

ГИШҮҮНИЙ

бүрэлдэхүүнтэйгээр байгуулж,
харьяалах нутаг дэвсгэрийнхээ
хэмжээнд нийтэд мэдээлнэ.



V.8

өдрөөс өмнө

СУМ, ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН
ХОРОО ХЭСГИЙН ХОРООГ
дарга болон

6-8

ГИШҮҮНИЙ

бүрэлдэхүүнтэй байгуулж,
харьяалах нутаг дэвсгэрийн
хэмжээнд нийтэд мэдээлнэ.



СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийг аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд сум, дүүргийн сонгуулийн хороо, сонгуулийн хэсэгт хэсгийн хороо зохион байгуулж явуулна.

Сонгуулийн ерөнхий хороо

Сонгуулийн ерөнхий хороо нь орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулж явуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо

Аймаг, нийслэлийн Хурал 2025 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга болон тав, эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ.

- » аймаг, нийслэлийн нөхөн Хурлын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх, үнэмлэх олгох;
- » саналын хуудаст бичигдэх нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг иргэний үнэмлэхийн мэдээлэлтэй тулган нягталж, баталгаажуулан үнэн зөвийг хариуцах;
- » аймаг, нийслэлийн Хурлын нөхөн сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, нийтэд мэдээлэх;
- » аймаг, нийслэлийн Хурлын Төлөөлөгчөөр сонгогдсон тухай шийдвэрийг аймаг, нийслэлийн Хуралд өргөн мэдүүлэх;
- » аймаг, нийслэлийн Хурлын сонгуулийн нэмэлт санал хураалт, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулж явуулах ажлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд хуульд заасны дагуу зохион байгуулах;
- » сум, дүүргийн сонгуулийн хороодын үйл ажиллагааг зохион байгуулалтын хувьд нэгдсэн удирдлагаар хангах;
- » сум, дүүргийн сонгуулийн хорооны ээлжит, ээлжит бус, нөхөн болон

дахин сонгууль, нэмэлт санал хураалтын үеийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

- » сонгууль зохион байгуулахтай холбогдсон асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх зохих шатны төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн удирдах албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;
- » Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороонд хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;
- » саналын хуудас болон сонгуульд ашиглах техник хэрэгслийг хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;
- » аймаг, нийслэлийн Хурлын сонгуульд харьяалах сонгуулийн хороодын шийдвэрийн талаарх өргөдөл, гомдлыг бүрэн эрхийн хүрээнд хянан шийдвэрлэх, хариуг бичгээр өгөх, доод шатны сонгуулийн хорооны хуульд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох;
- » санал хураалтын дүн, холбогдох баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу хүргүүлэх;
- » сум, дүүргийн сонгуулийн хороог байгуулах, дахин сонгуулийг товлон зарлах;
- » сонгууль зохион байгуулахтай холбогдуулан дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд өгсөн үүргийг биелүүлэх;
- » бусад.

Сум, дүүргийн сонгуулийн хороо

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус, нөхөн сонгуулиар тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн сонгуулийн хороог 2025 оны 4 дүгээр сарын 23-ны

өдрөөс өмнө дарга, нарийн бичгийн дарга, гурав, эсхүл таван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

- » сонгууль зохион байгуулах ажлыг төлөвлөх, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авах;
- » сум, дүүргийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх, үнэмлэх олгох;
- » сум, дүүргийн Хурлын сонгуулийн саналын хуудаст бичигдэх нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг иргэний үнэмлэхийн мэдээлэлтэй тулган нягталж, баталгаажуулан үнэн зөвийг хариуцах;
- » сум, дүүргийн Хурлын нөхөн сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, нийтэд мэдээлэх;
- » сум, дүүргийн Хурлын Төлөөлөгчөөр сонгогдсон тухай шийдвэрийг аймаг, нийслэлийн Хуралд өргөн мэдүүлэх;
- » нутаг дэвсгэртээ явагдсан аймаг, нийслэлийн Хурлын нөхөн сонгуулийн дүнг нэгтгэж, дээд шатны сонгуулийн хороонд хүргэх;
- » сум, дүүргийн Хурлын нэмэлт санал хураалт, ээлжит бус, дахин болон нөхөн сонгууль зохион байгуулж явуулах ажлыг эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;

- » харьяалах хэсгийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулалт, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;
- » аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, харьяалах хэсгийн хорооны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг гаргах, зарцуулалтад хяналт тавих;
- » өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, хариуг бичгээр өгөх;
- » харьяалах хэсгийн хорооноос ирүүлсэн санал хураалтын дүнг нэгтгэж, харьяалагдах аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргэх;
- » дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;
- » сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;
- » саналын хуудас болон сонгуульд ашиглах техник хэрэгслийг хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;

- » хуульд заасан бусад.

Хэсгийн хороо

Сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн 2025 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс өмнө дарга болон зургаа, эсхүл найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

- » хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;
- » санал авах байр, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, сонгогчийн бүртгэлийн болон санал авах, тоолох, дүн гаргах, дамжуулах төхөөрөмж /цаашид "санал тоолох төхөөрөмж" гэх/ зэрэг санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;
- » санал хураалтын дүнг танилцуулах, нэн даруй дамжуулах;
- » сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу гаргаж, сум, дүүргийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;
- » дээд шатны сонгуулийн хорооноос хуульд заасны дагуу өгсөн үүргийг биелүүлэх;
- » хуульд заасан бусад чиг үүрэг.



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН НӨХӨН

СОНГУУЛЬ-2025



2025.04.23
2025.06.23

Иргэний шилжилт
хөдөлгөөнийг зогсооно.

Иргэний шилжилт хөдөлгөөнийг зөвхөн нөхөн сонгууль
явуулах тухайн хэсгүүдэд зогсооно

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

Иргэний шилжилт хөдөлгөөнийг зөвхөн нөхөн сонгууль явуулах тухайн хэсгүүдэд зогсооно

Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ гэж хуульчилсаны дагуу зөвхөн нөхөн сонгууль явуулах тухайн хэсгүүдийн иргэний шилжилт хөдөлгөөнийг 2025 оны 4 дүгээр сарын 23-наас зогсоож 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр сэргээх юм.

Сонгогч Таны амьдардаг сум, дүүрэг, аймагт нөхөн сонгууль болох бол дараах алхмыг хийгээрэй.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлддэг. Та сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө (2025.06.08-аас өмнө) шалгасан байвал зохино.

МЭДЭЭЛЛЭЭ ХЭРХЭН ШАЛГАХ ВЭ ?

1-р алхам:

Та Улсын бүртгэлийн ерөнхий газрын <https://election.burtgel.gov.mn/> цахим санд Иргэний бүртгэлийн дугаар эсхүл регистрийн дугаараа бичиж бүртгэлтэй хаяг цонхонд оршин суугаа аймаг (нийслэл), сум (дүүрэг), баг (хороо)-ийг сонгож “шалгах” товчийг дарна.

2-р алхам:

“Шалгах” товчийг дарснаар Таны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, нас, хүйс, дэлгэрэнгүй хаяг, үндсэн хаяг дээрээ байгаа эсэх төлөв, сонгуулийн хэсгийн дугаар, санал өгөх байрны хаяг, тухайн хаягт бүртгэлтэй сонгогчийн тоо гарна.



3-р алхам:

“Сонгогчийг харах” сонголтыг идэвхжүүлснээр танай хаягт бүртгэлтэй сонгогчдын нэр гарна.

Сонгогчийг харах 1

4-р алхам:

Таны мэдээлэл зөв бол “мэдээлэл зөв” сонголтыг хийнэ.

Мэдээлэл зөв

МЭДЭЭЛЭЛ ЗӨРҮҮТЭЙ БОЛ ЯАХ ВЭ ?

1-р алхам:

Зөрүүтэй буюу буруу мэдээллийн арын сумыг дарж идэвхжүүлнэ. Жишээ нь таны оршин суугаа хаяг зөрүүтэй бол “Дэлгэрэнгүй хаяг”, танай хаягт бүртгэлтэй сонгогчийн тоо зөрүүтэй бол “сонгогчийн тоо” гэсэн мэдээллийн арын сумыг хойш түлхэж идэвхжүүлнэ. Ингэснээр “зөрүүтэй мэдээлэл” цэс улаан өнгөтэй болж, дарахад идэвхжинэ.

Мэдээлэл зөрүүтэй

2-р алхам:

“мэдээлэл зөрүүтэй” хэсгийг идэвхжүүлснээр таны мэдээлэл, гомдол бичих цонх гарч ирнэ. Энэ хэсэгт та идэвхтэй ашигладаг холбоо барих дугаар болон и-мэйл хаягаа бичнэ үү. Нэмэлт тайлбар цонхонд мэдээлэл, гомдлынхоо утгыг бичээд “илгээх” товч дарна.

Илгээх

3-р алхам:

“илгээх” товчийг дарснаар “Таны зөрүүтэй мэдээллийг шалгуулахаар ... дүүргийн /аймгийн/ улсын бүртгэлийн хэлтэст шилжүүллээ. Баярлалаа” гэдэг мэдээлэл гарч ирнэ. Ингэснээр Таны мэдээллийг бүртгэлийн байгууллага шалгаж, холбогдох хариуг өгөх юм.

4-р алхам:

Түүнчлэн Та улсын бүртгэлийн байгууллагад биечлэн хандаж мэдээллээ засуулах боломжтой.



НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

Нам, эвслийг төлөөлж тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэг дэх намын салбар байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, орон нутгийн Хурлын сонгуульд оролцох тухай хүсэлтээ санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө (2024.04.23-наас өмнө) тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ.

Тухайн шатны сонгуулийн хороо нам, эвслийн сонгуульд оролцох тухай баримт, бичгийг хүлээн авснаас хойш 5 хоногт багтаан бүртгэх, эсэх шийдвэр гаргана.



ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ХОРООНД НЭР ДЭВШИГЧЭЭР БҮРТГҮҮЛЭХДЭЭ ДАРААХ БИЧИГ БАРИМТЫГ БҮРДҮҮЛНЭ.

Нам эвслээс нэр дэвшигчдийн баримт бичгийг тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ. Баримтыг www.e-election.mn цахим системд бүрдүүлэх боломжтой.

Нам, эвслээс нэр дэвшигч болон бие даан нэр дэвшүүлэгч нь 2025 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн дотор дараах баримт бичгийг тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлдэг.



Нам, эвслээс нэр дэвшигчийн бүрдүүлэх материал:

- » Нэр дэвшүүлсэн тухай хуралдааны

шийдвэр, нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт

- » Нэр дэвшигч бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл
- » Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн шийдвэрийн хуулбар
- » Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа
- » Нэр дэвшигч өөрөө татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, нэр дэвшигч нь компанийн хувьцааны 51 хувь ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг

бол тухайн компани нь татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт

- » Нэр дэвшигчийн намтар
- » Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар
- » Ял эдэлж байгаа эсэх талаарх Цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа
- » Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг
- » Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.




НАМ, ЭВСЛЭЭС
НЭР ДЭВШИГЧ
БОЛОН БИЕ
ДААН НЭР
ДЭВШҮҮЛЭГЧ

2025
V.17

өдрийн дотор



БАРИМТ
БИЧГИЙГ
ТУХАЙН
ШАТНЫ
СОНГУУЛИЙН
ХОРООНД
ХҮРГҮҮЛДЭГ



Бие даан нэр дэвшигчийн бүрдүүлэх материал:

- » нэрээ дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдэл;
- » сонгогчдын гарын үсэг зуруулсан баримт (Нэр дэвшүүлэх ажиллагаа явагдаж эхэлсэн өдрөөс эхлэн аймаг, дүүргийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч 201-ээс доошгүй, нийслэлийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч 501-ээс доошгүй, сумын Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч 51-ээс доошгүй сонгогчийн гарын үсгийг e-election.mn цахим системээр эсхүл цаасаар зуруулна.);
- » Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн шийдвэрийн хуулбар /2024.8.1-ний өдрөөс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна./
- » Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүх болон арбитрын шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа /Тухайн орон нутаг дахь ШШГБ-аас лавлагаа авах/
- » Нэр дэвшигч өөрөө татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, нэр дэвшигч нь компанийн хувьцааны 51 хувь ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт
- » Нэр дэвшигчийн намтар
- » Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар
- » бие даан нэр дэвшигчийг төлөөлж сонгуулийн төв байгууллагатай харилцах хоёр хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, харилцах утасны дугаар;
- » төрийн аудитын дээд байгууллагаар хянуулсан бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлт;
- » ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа;
- » Нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг
- » Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх холбогдох байгууллагын лавлагаа.

Нэр дэвшигчийг бүртгэх тухай шийдвэр гарсан бол тухай шатны сонгуулийн хороо нэр дэвшигчийн үнэмлэхийг 2025 оны 6 дугаар сарын 7-ны өдөр олгож, нийтэд мэдээлнэ.

НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ

- ✗ Хуульд заасан хугацаанд нэр дэвшүүлэх ажиллагааг явуулаагүй /Нэр дэвшүүлэх ажиллагаа 2025 оны 5 дугаар сарын 8-аас 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрийг дуустал явагдана/;
- ✗ Хуульд заасан нэр дэвшигчид тавих шаардлагыг хангаагүй;
- ✗ Өөр намын гишүүнийг нэр дэвшүүлсэн /Нэг намын гишүүнийг өөр намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхийг хориглоно./;
- ✗ Нэр дэвшигчийг бүртгүүлэхэд шаардагдах хуульд заасан баримт бичгийн бүрдэл дутуу;
- ✗ Нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичиг хуурамч болохыг шүүх тогтоосон;
- ✗ Хуульд зааснаас бусад тохиолдолд давхар нэр дэвшсэн /Сум, дүүргийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь аймаг, нийслэлийн Хурлын Төлөөлөгчид зэрэг нэр дэвшиж болно./;
- ✗ Сонгогчдын санал татах зорилгоор хориглосон үйл ажиллагаа явуулсан болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон /сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн болох нь тогтоогдсон" гэж сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн болохыг шүүхээс тогтоож, тухайн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон байхыг ойлгоно./;
- ✗ Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцээгүй;
- ✗ Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, ийм агуулга бүхий мэдээллийг хэвлэмэл хэлбэрээр, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараасан болох нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон.



НЭР
ДЭВШҮҮЛЭХ
АЖИЛЛАГАА

2025
V.8-14

өдрийг дуустал
явагдана



НАМ ЭВСЭЛ

2025
IV.16

өдрөөс өмнө

БИЕ ДААН НЭРЭЭ
ДЭВШҮҮЛЭГЧ

2025
IV.29

өдрөөс өмнө

сонгуулийн МӨРИЙН
ХӨТӨЛБӨРТӨӨ ДҮГНЭЛТ
ГАРГУУЛАХаар төрийн аудитын
байгууллагын орон нутаг дахь
салбар байгууллагад хүргүүлсэн
байх шаардлагатайц





СУРТАЛЧИЛГАА



Сонгуулийн сурталчилгааг хэн хийх вэ?

- » Нам, эвслийн дарга, эсхүл түүний итгэмжлэл олгосон албан тушаалтан, ажилтан болон нэр дэвшигч, түүний менежер, шадар туслагч, ухуулагч (сонгууль эрхэлсэн байгууллага) сонгогчидтой уулзах, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сурталчлах зэрэг сонгуулийн сурталчилгааг хийнэ.
- » Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно.



Сонгуулийн сурталчилгаа хийх хугацаа

Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно.

(2025.06.07-ООС
ЭХЛҮҮЛЖ 2025.06.20-
НЫ 24.00 ЦАГААС ӨМНӨ
ЗОГСОНО).



Сонгуулийн сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулна.

- » сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;
- » нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;
- » хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах;

- » сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;
- » ухуулах байр ажиллуулах;
- » радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;
- » цахим орчин ашиглах-Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудсыг 2025.06.10-ны дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.
- » өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.
- » Сонгуулийн сурталчилгааны уулзалт, хандивын талаар сонгогчдод зар, урилга явуулсныг сурталчилгааны хэвлэмэл материалд оруулан тооцохгүй. Зар, урилга нь А5 хэмжээнээс илүүгүй байна.
- » Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн

нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна. Радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдана.



Тээврийн хэрэгсэл ашиглах

- » Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны зорилгоор нэг хэсэгт хоёроос илүүгүй тээврийн хэрэгсэл ашиглаж болно.
- » Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан таних тэмдэггүй авто машин, автобус, мопед, мотоцикл болон бусад тээврийн хэрэгслийг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хориглоно.
- » Сонгуулийн сурталчилгаанд ашиглаж байгаа тээврийн хэрэгсэлд сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас,

зурагт самбар, дэлгэц, уриа, намын далбаа, чанга яригч байрлуулж болно.



Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материал

- » Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг дараах хэлбэр, хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр сонгогчдод тараах эрхтэй:
 - гурван хэвлэлийн хуудас сонин;
 - гурван хэвлэлийн хуудас сэтгүүл;
 - нэг хэвлэлийн хуудас ухуулах хуудас.
- » Нэг нам, эвслийн нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалаа нэгдмэл байдлаар хамтран гаргаж болно.
- » Сурталчилгааны хэвлэмэл материалыг шуудангаар хүргүүлж болно.



- ✗ Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон байршлаас өөр газарт зурагт самбар, ухуулах хуудас байршуулахыг хориглоно.
- ✗ Нам, эвсэл, нэр дэвшигчийн зурагт болон ухуулах хуудсыг гэмтээх, устгахыг хориглоно.



Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар, дэлгэц

- » Сонгуулийн сурталчилгаанд зурагт самбар, дэлгэц ашиглаж болно. Зурагт самбар, дэлгэц нь нэг хэсэгт 10-аас илүүгүй байна.
- » Зурагт самбар, дэлгэц нь хоёр хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй, хөдөлгөөнт хэлбэртэй байж болох бөгөөд хэлбэр, загварт хязгаарлалт тавихгүй.
- » Зурагт самбар, дэлгэцийг энэ хуулийн Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон байршилд үнэ төлбөргүй байрлуулна.
- » Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.
- » Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга, байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар, дэлгэц байрлуулахгүй.
- » Нэг нам, эвслийн нэр дэвшигчид хамтран сурталчилгааны нэг самбар, дэлгэцтэй байж болох бөгөөд энэ тохиолдолд хариуцлагыг хамтран хүлээнэ.
- » Зурагт самбар, дэлгэцэд тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг заавал дурдсан байна.



- ✗ Сонгуулийн сурталчилгааны хугацаанд гудамж талбайд байрлуулсан сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэцийг гэмтээх, устгахыг хориглоно.
- ✗ Зурагт самбар, дэлгэцийг байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчид аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.



Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх

- » Сонгогчидтой хийх уулзалт, хурал, цуглааныг сонгуулийн сурталчилгааны хугацаанд багтаан хийнэ.
- » Уулзалт, хурал, цуглаан зохион байгуулахад нь тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, сонгуульд оролцогч талуудад тэгш хандах үүрэгтэй.

- » Шүүх, прокурор, тагнуул, цагдаа, онцгой байдлын болон эмнэлгийн байгууллагаас бусад төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд үнэ төлбөргүйгээр ашиглуулах үүрэгтэй



Ухуулах байр ажиллуулах

- » Нэр дэвшигч сонгуулийн хэсэг бүрд сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлах, танилцуулах, сурталчилгааны материал тараах, уулзалт, хурал цуглаан зохион байгуулах зорилгоор хоёроос илүүгүй ухуулах байр ажиллуулж болно.
- » Нэг нам, эвслээс нэр дэвшигчид хамтран нэг ухуулах байранд үйл ажиллагаа явуулж болно.



Сонгуулийн сурталчилгаа хийх, сонгогчдын саналыг татах зорилгоор

дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно

- » мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүйгээр үзүүлэх;
- » нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх;
- » сонгогчийг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах;
- » ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх;
- » хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах;
- » сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;

- » хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэх.



Сонгуулийн сурталчилгааны явцад хориглох зүйл

- » Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;
- » Зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;
- » Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах;
- » Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн

сурталчилгаанд ашиглах;

- » Оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах;
- » Олон нийтийг хамарсан аливаа шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашны холбогдолтой эд зүйл тараах.
- » Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг, түүнчлэн сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлэх, нийтлэхийг хориглоно.
- » Сонгуулийн сурталчилгаа хийх эрх бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэх зорилгоор тэдгээрийн нэрийн өмнөөс аливаа этгээд санаатайгаар хууль бус сурталчилгаа хийхийг хориглоно.
- » Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.





С.ТАМИР: НӨХӨН СОНГУУЛИЙН ДҮНГ ЦАХИМ ХУУДСААР МЭДЭЭЛНЭ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулиар сонгуулийн мэдээллийн www.e-election.mn цахим системийг хэрхэн ашиглах болон сонгуулийн автоматжуулсан системийн бэлэн байдлын талаар Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тамиртай ярилцлаа.

Сонгуулийн мэдээллийн цахим систем www.e-election.mn -ийн үйл ажиллагаа улам өргөжсөөр байна

-Улсын Их Хурал болон Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд ажиллах хүний нөөц, нэр дэвшигчдийн бүртгэлээс эхлээд дүн дамжуулахад сонгуулийн мэдээллийн www.e-election.mn цахим системийг ашигласан. Нөхөн сонгуульд системээ ашиглах уу?

-Сонгуулийн ерөнхий хороо www.e-election.mn цахим системийг 2023 оны

нөхөн сонгууль болон 2024 оны хоёр удаагийн ээлжит сонгуульд ашигласан. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд дахин ашиглана. Уг систем бүхэлдээ сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагааг цахимжуулсан хувилбар болж өргөжсөн бөгөөд Сонгуулийн ерөнхий хороо, байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагууд, улс төрийн нам, нэр дэвшигч болон нам, эвсэл, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагч, ажиглагч, сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийн бүртгэл,

баталгаажуулалтыг цахимжуулж, мэдээллийн санг бий болгож байгаагаараа онцлог болсон.

-Сонгуулийн байгууллагад ажиллах албан хаагчид болон нэр дэвшигчид системээр бүртгүүлэх үү?

-Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах төрийн албан хаагчид www.e-election.mn системээр сургалтын материалтай танилцах, гэрчилгээ олгох үйл ажиллагаа системд нээлттэй бөгөөд өмнө нь цахимаар сургалтад

хамрагдаж гэрчилгээ авсан бол дахин сургалтад хамрагдах шаардлагагүй. Суралцагчийн эрхээрээ орж тухайн сонгуулийн хэсгийн хороо болон мэдээллийн технологийн баг, даамлаар ажиллах хүсэлтээ илгээх боломжтой.

Харин нэр дэвшигчийг бүртгэх хуулийн хугацаанд сонгуульд оролцож буй нам, эвсэл, бие даагчдад системд нэвтрэх эрхийг нам, эвсэл болон харьяа сонгуулийн хороодод өгдөг. Ингэснээр нэр дэвшигч системээр нэр дэвшигчийн бүрдүүлэх материалыг илгээх боломжтой болно. Давуу тал нь төрийн бусад байгууллагуудаас авдаг лавлагаануудыг системээс буюу төрийн мэдээлэл солилцооны ХУР-аас дуудах бүрэн боломжтой. Мөн нэр дэвшигчийн бүртгэлийг тухайн шатны сонгуулийн хороод баталгаажуулсны дараа нэр дэвшигч сонгуульд ажиллах менежер, шадар туслагч, ухуулагч болон сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслээ бүртгэж, үнэмлэхийг хэвлэн зохих шатны хороогоор баталгаажуулна. Системийг ашиглан зохион байгуулснаар үйл ажиллагааны явцад иргэний үнэмлэх болон тээврийн хэрэгслийн гэрчилгээ зэрэг төрд байгаа мэдээллийг цаасаар барьж очиж баталгаажуулах шаардлагагүй болсон.



-Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны урьдчилсан дүнг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсаар дамжуулсан. Энэ удаад яах вэ?

-Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг Сонгуулийн ерөнхий хорооны <https://m-election.mn> цахим хуудсаар иргэд олон нийтэд нээлттэй танилцуулсан. Энэ удаагийн сонгуулийн дүнг мөн адил цахим хуудсаараа нээлттэй танилцуулна. Бид нэр дэвшигчдийг цахимаар бүртгэж, баталгаажуулж байгаа учраас нэр дэвшигчийн авсан саналын дүнг эрэмбэлэн харуулах, дэлгэрэнгүй мэдээллийг нь сонгогчдод нээлттэй байлгах чиглэлээр ажиллаж байна.

Сонгуулийн автоматжуулсан системийг туршиж, баталгаажуулан гэрчилгээ олгох ажлыг нам, эвсэл,

“

СИСТЕМ БҮХЭЛДЭЭ СОНГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛСАН хувилбар болж өргөжсөн бөгөөд Сонгуулийн ерөнхий хороо, байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагууд, улс төрийн нам, нэр дэвшигч болон нам, эвсэл, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагч, ажиглагч, сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийн бүртгэл, баталгаажуулалтыг цахимжуулж, МЭДЭЭЛЛИЙН САНГ БИЙ БОЛГОЖ БАЙГААГААРАА ОНЦЛОГ БОЛСОН.

СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ СИСТЕМ

Сонгуулийн байгууллагын бүтээмж, мэдэ солилцооны үр ашгийг нэмэгдүүлэх, олон нээлттэй, ил тод мэдээллээр хангана.

Нэвтрэх хэсэг

Системийн хэрэглэгч

Хэрэглэгчийн нэр

Нууц үг

Нүгц үзэв мартсан?

Бүртгүүлэх

Нэвтрэх

Дангаар нэвтрэх



олон нийтийн хяналт дор гүйцэтгэж байна.

-Санал тоолох төхөөрөмжийн бэлэн байдал хангагдсан уу?

-Монгол Улсын Их Хурлын 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 20 дугаар тогтоолын дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд "New Image Cast" санал тоолох төхөөрөмжийг хэрэглэхийг зөвшөөрсөн байдаг.

Энэ дагуу санал тоолох төхөөрөмжийг сонгуулийн үйл ажиллагаанд ашиглах бэлтгэл ажил хэвийн явагдаж байна. Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвөөс санал тоолох төхөөрөмжийг сонгуульд ашиглах сургалтыг онол, дадлага хосолсон хэлбэрээр зохион байгуулдаг.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд зааснаар МТТ-өөс зохион байгуулж буй дээрх сургалтад хамрагдсан мэдээллийн технологийн даамал нь хэсгийн хороонд санал тоолох төхөөрөмжийг ашиглаж сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах эрхтэй болдог.

-Санал тоолох төхөөрөмжийг туршиж, баталгаажуулдаг. Нөхөн сонгуульд ч энэ үйл ажиллагааг зохион байгуулдаг уу?


-Сонгуулийн автоматжуулсан системийг шалган туршиж, баталгаажуулан гэрчилгээ олгох ажлыг Мэдээллийн технологийн төв, ЦХИХХЯ, ТЕГ-ын холбогдох мэргэжлийн албан хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хийж гүйцэтгэдэг. Ажлын хэсэг САС-ийг шалгаж баталгаажуулах ажлын хүрээнд УБЕГ-т сонгогчдын нэрийн жагсаалтын программ хангамжийн эх код болон сонгогчийн бүртгэлийн зөөврийн компьютеруудыг нэг бүрчлэн шалгаж, гэрчилгээжүүлэн ажилладаг. Мөн СЕХ-

нд санал тоолох төхөөрөмж түүний иж бүрдэл, систем, серверийн үйл ажиллагааг шалгаж баталгаажуулан гэрчилгээ олгож ажилладаг. Энэ үйл ажиллагааг сонгуульд оролцож буй нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн ажиглагч нарын хяналтан дор зохион байгуулан ажилладаг бөгөөд сүүлийн сонгуулиудад хэвлэл мэдээлэл болон төрийн бус байгууллагуудыг нээлттэй оролцуулж байгаа.

-Санал авах байруудыг камержуулах, алслагдсан байруудаас дүн дамжуулах ажил бэлэн үү?

-Бид 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас хойш бүх санал авах байруудад хяналтын камер байрлуулж дэд бүтцийн боломжтой газруудыг хяналтын камерын нэгдсэн системд холбож ажиллаж байна. Хяналтын камерын нэгдсэн системд холбогдсон санал авах байруудыг тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд болон сонгуульд оролцож буй нам, эвсэл, зохих шатны сонгуулийн хороод болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандах эрх нээн өгч, хяналт тавих боломжийг бүрдүүлж өгсөн. Энэ нь сонгуулийн үйл ажиллагааны явцад гардаг олон асуудлыг нээлттэй болгосон давуу талтай.

2024 оны ээлжит сонгуулиар старлинкийн төхөөрөмжийг ашиглаж сүлжээнд холбогдоогүй санал авах байруудаас дүн хүлээн авах ажлыг зохион байгуулсан бөгөөд старлинка ашиглаж байгаа алслагдсан хэсгийн санал авах байруудыг хяналтын камерын нэгдсэн системд холбох ажлыг амжилттай зохион байгуулсан. Энэ удаагийн сонгуульд мөн адил ашиглахаар бэлтгэл ажлыг хангаж байна.



СОНГОГЧ САНАЛАА ӨГӨХ ДАРААЛАЛ, АНХААРАХ БОЛОН ХОРИГЛОХ ЗҮЙЛ




Сонгуулийн санал авах өдөр сонгогчийн хамгийн хариуцлагатай мөч бол санал авах байр руу явж саналаа өгөх явдал. Саналаа өгөх үйл явц нь гаднаас харахад нарийн төвөгтэй мэт харагдавч бодит байдал дээр тийм биш. Сонгуульд саналаа өгөхөд юу анхаарах талаар сонгогчдын боловсролын чиглэлээр ажилладаг олон төрийн бус байгууллагууд сонгогчдод хандан мэдээлэл, лавлагаа хүргэж ажилладаг тул санал авах байранд очихоос өмнө эдгээр байгууллагад хандан мэдээлэл авч болно. Түүнчлэн, сонгогч сонгуулийн байгууллагад хандан мэдээлэл, туслалцаа авах боломжтой бөгөөд энэ нь саналаа нууцаар гаргахад хамаарахгүй гэдгийг санах хэрэгтэй.

Санал авах байранд 11-15 цагийн хооронд болон санал авах байр хаах дөхсөн үед саналаа өгөх сонгогчдын ачаалал илүү их нэмэгддэг болох нь ирцийн мэдээнээс харагддаг. Тиймээс ажил төрөл, цаг хугацаагаа зохицуулаад аль болох эрт очиж саналаа өгч байгаарай. Саналаа өгсөн сонгогчийн дараагийн хийх хариуцлагатай ажил бол эргэн тойрны хүмүүсээ, найз нөхдөө саналаа өгсөн эсэхийг лавлаж, өгөөгүй бол даруйхан саналаа өгөх, сонголтондоо хариуцлагатай хандахыг уриалах явдал юм шүү.

Сонгуулийн санал авах өдөр санал авах байранд дараах үйл ажиллагаа болж өнгөрдөг.

- » Сонгогч саналаа өгөх;
- » Сонгуулийн дүн мэдээ гаргах, дамжуулах.



СОНГОГЧ САНАЛАА ӨГӨХ

Сонгогч санал авах байранд саналаа дараах журмаар өгдөг:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах ажиллагаа Улаанбаатарын цагаар 07.00-20.00 цагийн хооронд явагддаг.

Сонгуулийн хэсгийн хороод санал авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулах чиг үүрэг хүлээн ажилладаг. Сонгогчийн санал авах ажиллагаа дараах дараалын дагуу явагддаг.

- » Хэсгийн хороонд ажиллаж буй Улсын бүртгэлийн ерөнхий газрын итгэмжилсэн ажилтан санал өгөхөөр ирсэн сонгогчийн биеийн давхцахгүй өгөгдөл буюу гарын хурууны хээг тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулган үзэж, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.
- » Хэсгийн хорооны гишүүн сонгогчийн бүртгэлийн хуудсыг авч сонгогчид саналын хуудас олгоно.
- » Саналын хуудас авсан сонгогч

сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зурна.

- » Сонгогч санал бэлтгэх бүхээгт очиж, саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.
- » Сонгогч саналаа тэмдэглэсний дараа саналын нууцлалыг хангах зориулалт бүхий хавтсанд саналын хуудсаа хийнэ.
- » Энэхүү саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийнэ. Ингээд сонгогч санал авах байрыг орхиж гарна.

СОНГОГЧДОД САНАЛАА ӨГӨХӨД ДАРААХЬ ЗҮЙЛСИЙГ ХОРИГЛОДОГ:


Тухайн санал авах байранд санал өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх;



Өөр хүний бичиг баримт, хуурамч баримт бичиг ашиглаж санал өгөх, саналаа өгөхийг оролдох;



Тухайн хэсгийн хорооноос олгосноос өөр саналын хуудас ашиглах;



Санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, эсвэл авч гарах;



Саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан зураг авах, дүрс бичлэг хийх, шууд дамжуулах үйлдэл хийх;



Саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах, зориулалтын бус үзгээр санал тэмдэглэх;



Аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсвэл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.

САНАЛ АВАХ БАЙРАНД ХУУЛИАР ХОРИГЛОСОН ҮЙЛДЛЭЭС ДУРДВАЛ:

Санал авах байранд нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд саналаа өгөхөөс бусад тохиолдолд байхыг хориглоно.



Эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогчид туслалцаа үзүүлэх итгэмжилсэн иргэн нь 2-оос дээш сонгогчид туслалцаа үзүүлэх хориотой.



Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх аливаа тэмдэг, тэмдэглэгээ хийхийг хориглоно.



Сонгогч саналын хуудаст саналаа тэмдэглэх үед тухайн сонгогчийн дэргэд өөр хүн байхыг хориглоно.

“ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ” СУРГАЛТ


Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаар иргэдийн тогтмол мэдээ, мэдээллээр хангах, сонгуулийн боловсрол олгох сургалтыг өргөн хүрээнд, тогтмол явуулах чиг үүрэгтэй юм.

Монгол Улсын Хурлын ээлжит сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит

сонгуулиудын ирц, оролцоог насны бүлгээр авч үзвэл 18-25 насны сонгогчдын ирц сонгуулиас сонгуульд тогтмол буурсан үзүүлэлттэй байдаг. Судалгааны байгууллагуудын хийсэн судалгаануудаас үзэхэд 18-25 насны сонгогчид сонгуульд оролцохын ач холбогдол, сонгуулийн мөн чанарын талаарх ойлголт бүрэн бус, сул, мөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа, санал өгөх, санал тэмдэглэх, сонгуульд хэрхэн оролцох зэрэг ойлголт бүрэн бус, сул байдагтай холбоотойгоор сонгуулийн ирц оролцоог тогтмол буурч байгаа нь

харагддаг.

Сонгуулийн ерөнхий хороо залуу сонгогчдыг сонгуульд идэвхитэй оролцуулах, сонгуулийн мөн чанар, ач холбогдлыг тайлбарлан таниулах зорилгоор “Хариуцлагатай сонгогч” сургалтын хөтөлбөрийг батлан, 2025 оны 2, 4 дүгээр улиралд сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Одоогийн байдлаар Сонгуулийн ерөнхий хорооноос томилогдсон 80 сургагч багш байгаа бөгөөд тэд орон нутагтаа сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж ажиллаж байна.



“СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Д.Бат-Эрдэнэ

Ардчиллыг бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх гол хүчин зүйлийн нэг бол чөлөөт, шударга сонгууль юм.¹ Үндсэн хуульт ардчиллыг чөлөөт, шударга сонгуульгүйгээр төсөөлөх боломжгүй. Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч парламентыг чөлөөт, шударга, ардчилсан сонгуулийн үндсэн дээр ард түмэн өөрсдийн итгэл үнэмшил, хараат бус, чөлөөт сонголтоороо байгуулах нь Үндсэн хуульт ардчилал оршин байгаа эсэхийг тодорхойлох нэгэн гол хүчин зүйл юм. Ард түмний сонгосон хүмүүс хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг учраас эдгээр эрх мэдлийг хэрэгжүүлэх бүрэн эрх ардчилсан сонгуулийн дүнгээр улс төрийн нам, эвслийн хооронд шилждэг.²

Нөгөө талаар хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгчдэд шударгаар хариуцлага тооцох, хяналттай байлгах үндсэн аргын нэг бол чөлөөт, шударга сонгууль юм. Үүнийг улс төрийн хариуцлага тооцох үндсэн механизм ч гэж үзэх нь бий. Сонгууль бол хэнд төрийн эрх мэдлийг итгэмжлэн шилжүүлэхийг шийдэх ардчилсан арга бөгөөд сонгогдсон, томилогдсон албан тушаалтанд итгэл үзүүлэх эсхүл хариуцлага тооцох хяналтын тогтолцоо юм.³

Сонгуулийг ардчилсан сонгуулийн зарчимд нийцүүлэн хуулийн хүрээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий сонгуулийн төв байгууллага нь зөвхөн сонгуулийг зохион байгуулах бус сонгууль шударга, ил тод явагдах, сонгуулийн үйл явц, сонгогчийн эрх, үүрэг, ардчилсан засаглалд оролцохын ач холбогдлын талаар иргэдэд мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх, сонгуульд мэдээлэлтэй, идэвхтэй оролцохыг дэмжих, тэдний санал улс төрийн орчинд хэрхэн нөлөөлж байгааг ойлгоход нь туслах зорилгоор сонгуулийн боловсрол олгох чиглэлээр дэмжсэн бодлого хэрэгжүүлэх нь чухал юм.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль 1992 онд батлагдсанаас хойш Монгол Улсын Их Хурлын сонгууль 9 удаа, Ерөнхийлөгчийн сонгууль 8 удаа, орон нутгийн сонгууль 9 удаа зохион байгуулагдсан.

1992 онд зохион байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын анхны сонгууль, 1993 оны Ерөнхийлөгчийн анхны сонгуулийн үеэр сонгуулийн ирц 90 гаруй хувь, орон нутгийн

сонгуулийнх 70 гаруй хувьтай байсан. Үүнээс хойш бүх төрлийн сонгуулийн хувьд сонгогчдын ирц тогтмол буурсаар иржээ. Гурван төрлийн сонгуулиас УИХ-ын сонгууль нь хамгийн өндөр ирцтэй байдаг ба Орон нутгийн сонгууль нь иргэдийн хамгийн идэвх муутай оролцдог сонгууль бөгөөд ирц нь УИХ-ын сонгуулийнхаас 10-15 хувиар, Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц УИХ-ын сонгуулийнхаас 4-5 хувиар бага байдаг.

Анхны ардчилсан сонгуулиар (1992 болон 1996 он) 90 гаруй хувьтай байсан ирц сүүлийн сонгуулиудын хугацаанд 67-74 хувь болж буурсан харагдаж байна. Доорх Хүснэгт 1-д энэхүү тоог дэлгэрэнгүй харууллаа. Үүнээс бид УИХ-ын сонгуулийн ирц нь орон нутгийн болон Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцтэй харьцуулбал өндөр хэдий ч бүхий л гурван төрлийн сонгуулийн тухайд ирц буурсаар байгааг харж болно.

Хүснэгт 1. УИХ-ын сонгуулийн сонгогчдын ирц

№	Сонгууль	Сонгуулийн насны иргэдийн тоо	Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэлтэй сонгогчдын тоо	Ирц
1.	1992	1,202,704	1,085,129	95.6%
2.	1996	1,218,549	1,147,260	92.1%
3.	2000	1,364,862	1,247,033	82.4%
4.	2004	1,472,372	1,279,516	82.2%
5.	2008	1,607,825	1,542,617	76.46%
6.	2012	1,882,035	1,840,824	67.28%
7.	2016	1,998,823	1,911,047	73.58%
8.	2020	2,131,171	2,003,969	73.6%
9.	2024	2,107,290	2,103,044	69.6%

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь үндсэндээ Улсын Их Хурлын сонгуулиас бага ирцтэйгээр явагдаж иржээ (Хүснэгт 2). 1992 оноос хойш Монгол Улсад явагдаж буй бүхий л сонгуулиар сонгогчдын ирц буурч буй нийтлэг хандлагыг мөн ажиглаж болно. Мөн нэг жилийн хугацаанд дараалан зохион байгуулагддаг гурван төрлийн сонгуулийн сүүлийнх нь болох Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцэд ажиглагдаж буй энэхүү ирцийн зөрүүтэй байдлыг сонгогчдын сонгуулиас залхсан байдалтай холбон тайлбарлаж болох юм. Сонгуульд нэр дэвшигчдийн өрсөлдөөний талаарх иргэдийн бодол, нэр дэвшигчдийн нэр хүнд, тэдний идэвх

1 Civic Academy South Africa. Cultivating democracy through civic education. <https://civicsacademy.co.za/what-are-free-and-fair-elections/>

2 Мөнхсайхан, О. (2023). Үндсэн хуульт ардчиллын төлөө 2013-2023, ярилцлага, нийтлэл. УБ, 198 дугаар тал

3 ХБНГУ-н Конрад Аденауэр сан. (2016). "Иргэн таны оролцоо ардчиллын баталгаа", УБ., 31 дүгээр тал



“СОНГУУЛЬ-2024” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Легал дата” ХХК, “Тунгаахуй” өгөгдлийн урлантай хамтран их, дээд сургуулийн оюутан, судлаач, мэргэжлийн албан хаагчдын дунд “СОНГУУЛЬ-2024” эрдэм шинжилгээний уралдааныг 2024 оны 12 дугаар сард зарласан. Уралдаанд оюутан, судлаач, өмгөөлөгч, сэтгүүлч зэрэг 110 гаруй иргэн оролцсоноос зохион байгуулагчид 13 илтгэлийг хоёрдугаар шатанд хэлэлцүүлэх шаардлага хангасан гэж үзсэн юм.

Хоёрдугаар шатны хэлэлцүүлэгт оролцогчид Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор жендэрийн тэгш эрхийг дэмжсэн болон бусад хуулийн зохицуулалтын үр нөлөөг тодорхой дүгнэх, Сонгуулийн процессын эрх зүйд тулгамдаж буй асуудлыг бодит тоон мэдээлэлд тулгуурлан хөндөж, сайжруулах санал боловсруулах хоёр үндсэн сэдвийн хүрээнд илтгэлээ хэлэлцүүлсэн юм.

Уралдаанд эхний гурван байрт шалгарсан илтгэлийг “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүлд нийтлэх юм.

Энэ удаад Тэргүүн байрт шалгарсан илтгэлийг Уншигч Танд хүргэж байна.



“ЖЕНДЭРИЙН ТЭГШ ЭРХИЙГ ХАНГАХАД МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ”

Өмгөөллийн “Легал гайд” хуулийн фирмийн өмгөөлөгч,
судлаач **Э.ЭРДЭНЭХИШИГ**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНСДИТХСтХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
МУЗЗНДНТУтХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

МУИХСтХ

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль

СЕХ

Сонгуулийн Ерөнхий Хороо

УИХ

Улсын Их Хурал

УТНтХ

Улс төрийн намын тухай хууль

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-д "улс төр ... харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй ..." хэмээн жендэрийн тэгш эрхийг баталгаажуулсан. Улс төрийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй гэдэг нь эрх мэдэл шилжүүлэн өгөх, авах, хэрэгжүүлэх, хуваарилах, түүний төлөө эвлэлдэн нэгдэх зэрэг улс төрийн оролцооны бүх төрөл, хэлбэрийн хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүн ямар нэг ялгаварлалгүй оролцох эрх зүйн орчин бий болж, практик тогтсон байхыг ойлгоно хэмээн үздэг.¹

Энэхүү илтгэлээр жендэрийн тэгш эрх улс төрийн харилцаанд буюу 2024 оны УИХ болон орон нутгийн хурлын сонгуулиар² хэрхэн хэрэгжсэн байдлыг авч үзнэ. СЕХ, "Тунгаахуй өгөгдлийн урлан"-гийн сонгуулийн дата мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнг МУИХСтХ, уг хуульд 2023.06.16-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлт, АНСДИТХСтХ, УТНтХ, бусад хуулийн зохицуулалттай харьцуулав.

НЭГ.ЗОРИЛГО

2024 оны УИХ-ын ээлжит сонгууль 2019.12.20-ны өдөр батлагдсан МУИХСтХ, түүнд 2023.06.16-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлт³, орон нутгийн хурлын ээлжит сонгууль 2020.01.30-ны өдөр батлагдсан АНСДИТХСтХ, 2020.12.24-ний өдөр шинэчлэн батлагдаж, 2022.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн МУЗЗНДНТУтХ-ийн хүрээнд явагдсан. Түүнчлэн; УТНтХ 2023.07.07-ны өдөр шинэчлэн батлагдаж, 2024.01.01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн онцлогтой болно.

Энэхүү илтгэлээр 2024 оны УИХ болон орон нутгийн хурлын ээлжит сонгуулиар жендэрийн тэгш эрхийг хангахад дээрх хуулиуд хэрхэн нөлөөлсөн болохыг илрүүлэх зорилго дэвшүүлэв.

ХОЁРҮНДЭСЛЭЛ

2.1.УИХ-ын сонгууль

1992-2024 он хүртэлх найман удаагийн УИХ-д гурваас 13 эмэгтэй гишүүн байсан бөгөөд УИХ-ын гишүүдийн дөрвөөс 17.1 хувийг эзэлж байв.⁴ (зураг 1) УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УИХ-д 32 эмэгтэй гишүүн сонгогдсон ба эмэгтэй гишүүдийн эзлэх хувь 25.4 болж, 8.3 хувиар нэмэгдсэн. Ингэснээр УИХ дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувь Ази тивийн дундаж (21.4 хувь)-аас давж, дэлхийн дундаж (26.9

хувь)-д дөхсөн байна.⁵

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар сонгогдсон 32 эмэгтэй гишүүний 8 буюу 25 хувь нь УИХ-ын сонгуулийн тойргоос, 24 буюу 75 хувь нь жагсаалтаар сонгогдсон болно. Өөрөөр хэлбэл; УИХ-ын эмэгтэй гишүүдийн дийлэнх нь жагсаалтаар сонгогджээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг "Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно." гэж 2023.05.31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд 2024.01.01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон. Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор МУИХСтХ-д 2023.06.16-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд нэмэлт, өөрчлөлтөөс илтгэлийн сэдэв, агуулгад хамаарах хэсгийг авч үзье.

Хүснэгт 1.МУИХСтХ-ийн 2023.06.16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн агуулгын харьцуулалт

МУИХСтХ-ийн зүйл, хэсэг, заалт	Өмнөх агуулга	2023.06.16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт
§ 30.1	30.1.Нам, эвсэл сонгуульд 76-аас илүүгүй хүнийг нэр дэвшүүлнэ.	30.1.Нам, эвсэл нь 78 хүртэл хүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрогт, 48 хүртэл хүнийг нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаар тус тус нэр дэвшүүлнэ.
§ 30.2	30.2.Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.	30.2.Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.
§ 30.6	----	30.6.Нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэн нэр дэвшүүлнэ.
§ 33.1.10	----	33.1.10.энэ хуулийн 30.1, 30.2, ... 30.6-д заасан нэр дэвшүүлэх ажиллагааны журам зөрчсөн бол нийт нэр дэвшигчийг ... бүртгэхээс татгалзана.

1 Д.Лүндэндорж, "Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар", хоёр дахь хэвлэл, Улаанбаатар, 2024, 260 дугаар талд

2 Энэхүү илтгэлд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг тухайлан нэрлэхээс бусад нөхцөлд "орон нутгийн хурлын сонгууль" хэмээн ерөнхийлөн нэрлэв.

3 МУИХСтХ-д найман удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээрээс 2023.06.16-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийг судлаачаас "зарчмын шинжтэй" хэмээн үзэж тодруулав.

4 "Тунгаахуй өгөгдлийн урлан", <https://tungaahui.mn/pages/data-art-detail.php?id=115>

5 "Тунгаахуй өгөгдлийн урлан", <https://tungaahui.mn/pages/data-art-detail.php?id=112>

УИХ-ын гишүүдийн хүйсийн тэнцвэртэй байдал хангагдах эсэх нь нам, эвслийн нэр дэвшүүлэх ажиллагаанаас хамааралтай. Нам, эвсэл хүйсийн тэнцвэртэй байдлыг үл хангасан байдлаар нэр дэвшүүлж, сонгуульд оролцвол УИХ-ын гишүүдийн хүйсийн тэнцвэртэй байдал хангагдах боломжгүй.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УИХ дахь эмэгтэй гишүүдийн тоо нэмэгдсэн нь МУИХСтХ-д 2023.06.16-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хэмээн үзэх гурван үндэслэл байна. Нэгдүгээрт; МУИХСтХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт заасан аль нэг хүйсийн доод шаардлага 20 хувь байсныг нэмэгдүүлсэн бөгөөд ингэхдээ 2024 оны ээлжит сонгуулиар 30 хувь, 2028 оны ээлжит сонгуулиар 40 хувь болгосон. Хоёрдугаарт; МУИХСтХ-ийн 30 дугаар зүйлд 30.6 дахь хэсгийг шинээр нэмсэн бөгөөд жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай дарааллыг үндэслэнэ хэмээн тогтоосон. Гуравдугаарт; МУИХСтХ-ийн 33 дугаар зүйлд 33.1.10 дахь заалтыг шинээр нэмсэн бөгөөд нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ хуульд заасан аль нэг хүйсийн төлөөллийг хангах шаардлагыг биелүүлээгүй бол тухайн нам, эвслээс нэр дэвшүүлсэн нийт нэр дэвшигчдийг бүртгэхээс татгалзахаар хуульчилсан.

МУИХСтХ-ийн 2023.06.16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт нь УИХ дахь хүйсийн тэнцвэртэй байдал, жендэрийн тэгш эрх, эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг хангахад томоохон эерэг нөлөө үзүүлжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 2023.05.31-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр УИХ-ын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулах, УИХ-ын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгохоор хуульчилсан нь МУИХСтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах эх сурвалж болсныг онцлох нь зүйтэй.

Сонгуулийн тогтолцоо нь жендэрийн тэгш эрхийг хангах баталгаа болдог хэмээн зарим судлаачид үздэг. Тухайлбал; судлаач Э.Гэрэлт-Од "... 2011 онд баталсан МУИХСтХ-д эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан 20 хувийн квотыг хэрэглэж байгаа ч олон улсын болон Азийн орнуудын дунджаас доогуур байсаар байна. Сонгуулийн олонх дийлэнхийн тогтолцооны хувьд УИХ дахь эмэгтэйчүүдийн дэмжлэг дээд хязгаартаа тулсан. Цаашид эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийн тулд сонгуулийн тогтолцоог өөрчлөх хэрэгтэй..." гэж⁶, судлаач О.Алтантуяа "... Мажоритар тогтолцоонд эмэгтэйчүүдийн сонгогдох магадлал нь пропорциональ тогтолцоотой харьцуулахад бага байдаг..." гэжээ.⁷ "Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл" судалгааны тайланд "... Сонгуулийн тогтолцоо залуучууд болон эмэгтэйчүүдийг дэмждэггүй, улс төрийн намууд сонгуулийн хуулийн хүйсийн квотыг доод хязгаар гэж ойлгохгүй, тулгаж хэрэглэж байна..." гэж дүгнэсэн болно.⁸

Жендэрийн тэгш эрхийг хангахад УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулсан нь чухал нөлөө үзүүлжээ. МУИХСтХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт аль нэг хүйсийн төлөөллийн доод хязгаарыг тогтоохдоо 2024, 2028 оны ээлжит сонгуулиар хэмээн оныг тухайлан заасан нь УИХ-ын 2032 он, түүний дараах ээлжит сонгуулиудад хэрхэх нь ойлгомжгүй болох эрсдэл үүсэж болзошгүй байна.

Шинэчлэн батлагдсан УТНТХ-д жендэрийн тэгш эрхийг хангахад нөлөө үзүүлэхүйц гурван чухал зохицуулалт тусгагдсан. Нэгдүгээрт; УТНТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт хуульд заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог харгалзан төрөөс дөрвөн жилд нэг удаа санхүүжилт олгохоор хуульчилсан. Энэ нь нам, эвсэл эмэгтэй нэр дэвшигчийг МУИХСтХ-д заасан хүйсийн квотоос илүүгээр нэр дэвшүүлэх сонирхлыг нэмэгдүүлэх магадлалтай. СЕХ-ны урьдчилсан тооцооллоор ХҮН нам 20, Үндэсний эвсэл найм, Иргэний Зориг Ногоон нам долоо, Үнэн ба Зөв нам тав, Шинэ Нэгдсэн эвсэл хоёр, нийт 42 эмэгтэй нэр дэвшигчийг МУИХСтХ-д заасан хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн тул нийт 693 сая төгрөгийн санхүүжилт төрөөс олгохоор байна.⁹

Хоёрдугаарт; УТНТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.3.1-д намд жил бүр олгох төрийн санхүүжилт (УИХ-ын суудлын тоонд харгалзах)-ийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэхэд зарцуулахаар тусгасан. Энэ нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, улмаар УИХ болон орон нутгийн хурлын сонгуульд өрсөлдөх сонирхлыг дэмжинэ. СЕХ-ны урьдчилсан тооцооллоор Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам, Үндэсний эвсэл, Иргэний Зориг Ногоон нам, Шинэ Нэгдсэн эвсэл болон Үнэн ба Зөв намд нийт 6.5 тэрбум төгрөгийн санхүүжилт төрөөс олгохоор байна.¹⁰ Үүнээс эмэгтэй, ахмад, залуу болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог хангах, сургаж бэлтгэхэд багадаа 1.3 тэрбум төгрөгийг дээрх нам, эвсэл жил бүр зарцуулах боломж нээгдэнэ.

Гуравдугаарт; УТНТХ-д намын байгууллагад жендэрийн тэгш эрхийг хангах талаар зохицуулалт тусгагдсан. Тухайлбал; уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т энэ хуулийн 16.1-д заасан байгууллагыг бүрдүүлэхдээ дараах шаардлагыг хангана гээд 8.2.3-т "нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх.", 17 дугаар зүйлийн 17.7-д "Намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна." гэж заасан. УТНТХ-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар нам дотоод зохион байгуулалтаа УТНТХ-тай нийцүүлэх арга хэмжээг 2024.07.01-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэхээр тусгасан. Өөрөөр хэлбэл; намын байгууллагад жендэрийн тэгш эрхийг хангах зохицуулалт 2025.01.01-ний өдрөөс үйлчилнэ.

6 Э.Гэрэлт-Од, "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ /1992-2020/", 2021 он, 21 дүгээр талд

7 О.Алтантуяа, "Сонгуулийн тогтолцоо сонгох, сонгогдох эрхэд нөлөөлөх нь", "Эрх зүй" сэтгүүл, 2019 № 4, цуврал 48, 95 дугаар талд

8 "Цогц хөгжлийн үндэсний төв" төрийн бус байгууллага, "Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл" судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2021 он, 29 дүгээр талд

9 СЕХ-ны цахим хуудас, m-election.mn

10 СЕХ-ны цахим хуудас, m-election.mn

2.2. Орон нутгийн хурлын сонгууль

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нийт 17,728 нэр дэвшигч оролцсоноос 67.6 хувь нь эрэгтэй, 32.4 хувь нь эмэгтэй, үүнийг задлан үзвэл аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд оролцсон нийт 1,992 нэр дэвшигчийн 74.2 хувь нь эрэгтэй, 25.8 хувь нь эмэгтэй, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нийт 15,286 нэр дэвшигчийн 66.7 хувь нь эрэгтэй, 33.3 хувь нь эмэгтэй нэр дэвшигчид болно.¹¹

Шинэчлэн батлагдсан МУЗЗНДНТУХ-иар орсон гол өөрчлөлтийн нэг нь уг хуулийн 37 дугаар зүйлээр аймаг, сум, нийслэл болон дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийн тоог хүн амын тооноос хамааруулан тогтоосон явдал юм. Үүнтэй холбоотойгоор зарим аймаг, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийн тоо нэмэгдсэн, зарим нь буурсан. Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн тоо 45 хэвээр болно.

2022 оны байдлаар аймаг, нийслэлийн ИТХ-ын 682 төлөөлөгчийн 131 буюу 16.1 хувь нь эмэгтэй төлөөлөгчид байсан бол¹² 2024 оны ээлжит сонгуулиар нийт 796 төлөөлөгчийн 143 буюу 18 хувь нь эмэгтэй төлөөлөгчид байна. (зураг 2) Есөн аймгийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчийн тоо ихдээ дөрвөөр нэмэгдсэн бол найман аймгийн ИТХ-ын

эмэгтэй төлөөлөгчдийн тоонд өөрчлөлт ороогүй. Харин Увс, Дорнод, Архангай, Дорноговь болон Төв аймгийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн тоо ихдээ гурваар буурчээ.

2022 оны байдлаар сум, дүүргийн ИТХ-ын нийт 5,218 төлөөлөгчийн 2,089 буюу 28.6 хувь нь эмэгтэй төлөөлөгчид байсан бол¹³ 2024 оны ээлжит сонгуулиар нийт 7,235 төлөөлөгчийн 2,069 буюу 28.6 хувь нь эмэгтэй төлөөлөгчид байна.¹⁴ (зураг 3) Есөн аймгийн сумдуудын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчийн тоо ихдээ есөөр нэмэгдсэн бол гурван аймгийн сумдуудын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн тоонд өөрчлөлт ороогүй. Харин Баян-Өлгий, Завхан, Дархан-Уул, Өвөрхангай, Хэнтий, Өмнөговь, Булган, Сэлэнгэ болон Дорноговь аймгийн сумдуудын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн тоо ихдээ 18-аар буурчээ.

Дээрхээс үзвэл; аймаг, нийслэлийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн тоо нийт дүнгээр 2024 онд 12-оор нэмэгдсэн бол сум, дүүргийн ИТХ дахь эмэгтэй төлөөлөгчдийн тоо 20-иор буурчээ. 2024 онд Дорноговь аймгийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчийн тоо нэгээр, сумдуудын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчийн тоо гурваар буурсан нь аймаг, сум аль алинд эмэгтэй төлөөлөгчийн тоо буурсан аймаг болов.

11 "Тунгаахуй өгөгдлийн урлан", <https://tungaahui.mn/pages/data-art-detail.php?id=92>

12 "Тунгаахуй өгөгдлийн урлан", <https://tungaahui.mn/pages/data-art-detail.php?id=82>

13 "Тунгаахуй өгөгдлийн урлан", <https://tungaahui.mn/pages/data-art-detail.php?id=81>

14 "Тунгаахуй өгөгдлийн урлан", <https://tungaahui.mn/pages/data-art-detail.php?id=100>



АНСДИТХСтХ-д зургаан удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Эдгээрээс зарчмын шинжтэй гэж үзэх өөрчлөлт байхгүй ба бусад хуулийг дагалдуулан нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 2. АНСДИТХСтХ-ийн жендэрийн тэгш эрхийг хангахтай холбоотой зохицуулалт

Үзүүлэлт	АНСДИТХСтХ	Тайлбар
Сонгуулийн тогтолцоо	4.8. Орон нутгийн хурлын сонгууль олонхын /мажоритар/ тогтолцоотой байна.	
Нам, эвслээс нэр дэвшүүлэх	29.2. Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна.	
Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах	32 дугаар зүйлд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах есөн тохиолдлыг хуульчилсан.	Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тохиолдолд 29.2-т заасан шаардлага хамаарахгүй болно.

Орон нутгийн хурлын 2024 оны ээлжит сонгуулиар нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн аль нэг хүйсийн төлөөллийн доод хувь хэмжээ 20 байсан ба уг шаардлагыг хангаагүй нь нэр дэвшигчдийг бүртгэхээс татгалзах үндэслэл болохгүй тул бүртгэж, сонгуульд оролцуулжээ. Энэ нь МУИХСтХ-д зааснаас зөрүүтэй болно.

Шинэчлэн батлагдсан УТНтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт заасан хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог харгалзан төрөөс дөрвөн жилд нэг удаа олгох санхүүжилт нь зөвхөн МУИХСтХ-д хамаарах тул орон нутгийн хурлын сонгуульд нам, эвслээс эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэхэд дэмжлэг болж чадахгүй байна. 2019.11.14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Арванес1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана." гэх хэсгийг нэмсэн. Нам улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллахын тулд зөвхөн УИХ-д биш орон нутагт бэхжиж бодлого дэвшүүлэн ажиллах учиртай. Гэтэл намыг орон нутагт дэмжих зохицуулалт сул байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлд улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгааг заасан ч УИХ болон орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгаагүй, уг хуульд тусгах боломж хязгаарлагдмал тул УИХ болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага дахь жендэрийн тэгш эрхийг хангахад МУИХСтХ, АНСДИТХСтХ-д аль нэг хүйсийн төлөөлөлд тавих доод хувь хэмжээг тусгасан нь чухал болно.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Жендэрийн тэгш эрхийг хангахад МУИХСтХ, АНСДИТХСтХ болон УТНтХ эерэг болон сөрөг нөлөө үзүүлжээ. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УИХ дахь эмэгтэй гишүүдийн тоо 19-өөр нэмэгдэж 32 болж парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувь Азийн дундаж түвшинд хүрч, дэлхийн дундаж хэмжээнд дөхсөнөөс жендэрийн тэгш эрх тодорхой хэмжээнд хангагдсан хэмээн үзэв. Үүнд МУИХСтХ-ийн 2023.06.16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт, УТНтХ-ийн зохицуулалт эерэг нөлөө үзүүлсэн бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтийн гол үзэл санаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 2023.05.31-ний өдрийн өөрчлөлтөөс эх үндэстэй байна. Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан УИХ-ын сонгуулийн холимог тогтолцоо жендэрийн тэгш эрхийг хангахад чухал нөлөө үзүүлсэн болно.

МУИХСтХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт "... 2024, 2028 оны ..." хэмээн тусгайлан заасан нь УИХ-ын дараагийн сонгуулиудад хүйсийн шаардлага хэрэгжих эсэх талаар эргэлзээ үүсэж болзошгүй.

Орон нутгийн хурлын 2024 оны ээлжит сонгуулиар аймаг, нийслэлийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид 16.1-ээс 18 хувь болж "ялимгүй" нэмэгдсэн бол сум, дүүргийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн хувь 28.6 буюу өөрчлөгдөөгүй хэвээр байна. Тодруулбал; орон нутгийн хурлын жендэрийн тэгш эрхэд өмнөх үеэс ахиц дэвшил гарсангүй. Үүний гол шалтгаан нь АНСДИТХСтХ-тай холбоотой. Учир нь; жендэрийн тэгш эрхийн зохицуулалт МУИХСтХ, АНСДИТХСтХ-д ялгаатай бөгөөд МУИХСтХ-д 30-аас доошгүй гэсэн бол АНСДИТХСтХ-д 20-оос доошгүй хэмээн заасан. МУИХСтХ-д аль нэг хүйсийн төлөөллийн шаардлагыг хангаагүй бол нам, эвслээс нэр дэвшигчдийг нийтэд нь бүртгэхээс татгалзах зохицуулалттай, харин АНСДИТХСтХ-д ийм зохицуулалт байхгүй. Иймд, АНСДИТХСтХ-д заасан аль нэг хүйсийн төлөөлөл 20-оос доошгүй хувь байх шаардлагыг хэрэгжүүлэх зохицуулалт, хариуцлагын механизм дутагдалтай байна.

УТНтХ-иар намд төрөөс санхүүжилт олгохоор болсон нь дэвшилтэт зохицуулалт боловч уг санхүүжилт нь зөвхөн УИХ-ын сонгуульд хамааралтай, орон нутгийн хурлын сонгуульд үл хамаарахаар байна. Энэ нь нам үндэсний хэмжээнд бодлого дэвшүүлж ажиллах, орон нутгийн хэмжээнд бэхжихэд дэмжлэг болж үл чадна.

Дээрхэд үндэслээд, АНСДИТХСтХ-д жендэрийн тэгш эрхийг хангах, УТНтХ-д намын орон нутгийн хурлын сонгуулийн үр дүнгээс хамааран санхүүжилт олгох боломжтой эсэхийг нарийвчлан судлахыг зөвлөмж болгов.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг.Монгол Улсын Үндсэн хууль

Хоёр.Монгол Улсын хууль

- 2.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- 2.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;
- 2.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- 2.4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- 2.5. Улс төрийн намын тухай хууль;
- 2.6. Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль.

Гурав.Ном, сэтгүүл

- 3.1. Д.Лүндэндорж, "Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар", хоёр дахь хэвлэл, Улаанбаатар, 2024;
- 3.2. "Эрх зүй" сэтгүүл, 2019 № 4, цуврал 48.


Дөрөв.Судалгаа, тайлан

- 4.1. О.Алтантуяа, "Сонгуулийн тогтолцоо сонгох, сонгогдох эрхэд нөлөөлөх нь";
- 4.2. Э.Гэрэлт-Од, "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ /1992-2020/", 2021 он;
- 4.3. "Цогц хөгжлийн үндэсний төв" төрийн бус байгууллага, "Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл" судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2021 он.


Тав.Цахим хуудас

- 5.1. СЕХ-ны цахим хуудас, m-election.mn;
- 5.2. "Тунгаахуй өгөгдлийн урлан" цахим хуудас, <https://tungaahui.mn/pages>

Зураг 1. УИХ дахь эмэгтэй гишүүдийн тоо, эзлэх хувь (1992-2024 он)



Зураг 2. Аймаг, нийслэлийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн тоо, хувиар (2022, 2024 он)



Зураг 3. Сумын ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн тоо, хувиар (2022, 2024 он)¹

¹ Нийслэлийн дүүргийн тоон мэдээлэл дутуу байсан тул хамруулаагүй болно.



УЛС ТӨРИЙН НАМЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ ҮНДСЭН ХУУЛЬДАА ХЭРХЭН ТОДОРХОЙЛСОН ТАЛААРХ ХАРЬЦУУЛАЛТ



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Арван зургадугаар зүйл.

10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...

Арван ес1 дүгээр зүйл.

3.Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.

Арван зургадугаар зүйл.

10/...Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. ...



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

21 дүгээр зүйл

(1).Нам нь ард түмний улс төрийн хүсэл зориг бүрэлдэхэд оролцоно. Нам байгуулах нь чөлөөтэй. Намын дотоод дэг журам нь ардчилсан зарчимд нийцсэн байна. Нам өөрийн санхүүжилтийн эх үүсвэр ба түүний зарцуулалт, өөрийн хөрөнгийн талаар нийтэд тайлагнах үүрэгтэй.

(2).Зорилгоороо эсвэл дэмжигчдийнхээ зан байдлаар чөлөөт ардчилсан үндсэн дэг журамд хохирол учруулах эсвэл түүнийг устгахаар, эсвэл Холбооны Бүгд Найрамдах Герман улсын оршин тогтнолд аюул учруулахаар үйл ажиллагаа явуулсан намыг Үндсэн хуульд харш нам гэж үзнэ.

(3).Зорилгоороо эсвэл дэмжигчдийнхээ зан байдлаар чөлөөт ардчилсан үндсэн дэг журамд хохирол учруулах эсвэл түүнийг устгахад, эсвэл Холбооны Бүгд Найрамдах Герман улсын оршин тогтнолд аюул учруулахад чиглэсэн намд төрийн санхүүжилт олгохгүй. Санхүүжилт олгохгүй байх үндэслэл тогтоогдсон бол тухайн намд болон намд өргөсөн хандивт татварын хөнгөлөлт үзүүлэхгүй.

(4).(2) дахь хэсэгт заасны дагуу намыг Үндсэн хуульд харш нам гэж үзэх, (3) дахь хэсэгт заасны дагуу төрийн санхүүжилтээс хасах асуудлыг Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэнэ.

(5).Нарийвчилсан зохицуулалтыг Холбооны Улсын хуулиар тогтооно.

* "Гадаад орнуудын үндсэн хууль" номоос



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

16 дугаар зүйл

10. Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно; Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "... Нам нь улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.", 2.Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.

19 дүгээр зүйл

3.Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.



БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

11 дүгээр зүйл

Бүгд Найрамдах Польш Улсад улс төрийн нам байгуулах ба үйл ажиллагаа явуулах эрх чөлөөг хангана. Улс төрийн намууд улсын улс төрийн бодлогод ардчилсан аргаар нөлөөлөх зорилгоор өөрийн эгнээндээ Польшийн иргэдийн сайн дурын үндсэн дээр тэгш эрхтэйгээр элсүүлнэ.

11 дүгээр зүйл

Улс төрийн намуудын санхүү ил тод байна.




МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Арван ес1 дүгээр зүйл.

1.Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.

2.Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.

3.Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.




БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

4 дүгээр зүйл

Сонгуулийн явцад улс төрийн нам, бүлэглэлүүд санал бодлоо илэрхийлэхэд дэмжлэг үзүүлнэ. Намыг чөлөөтэй үүсгэн байгуулж үйл ажиллагааг явуулна. Улс төрийн нам, бүлэглэлүүд үндэсний бүрэн эрхт байдал, ардчилалын зарчмуудыг баримтлах үүрэг хүлээнэ.

Нам, бүлэглэлүүд хуулиар тогтоосон нөхцөлийн дагуу гуравдугаар зүйлийн сүүлийн хэсэгт заасан зарчмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.





МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

16 дугаар зүйл


16.10. Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

19.1 Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.

2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.

Улс төрийн намын санхүүжилт:

Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцлийг хуулиар тогтооно.



БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

8 дугаар зүйл


8.1. Нам байгуулагдах нь чөлөөтэй бөгөөд олон намын тогтолцоотой байна.

8.2. Нам нь ардчилсан зорилго, зохион байгуулалт, үйл ажиллагаатай байх ба иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэхэд шаардлагатай байгууллага байна.

8.3. Нам нь хуульд заасны дагуу төрийн хамгаалалт байх бөгөөд төр нь хуульд заасан үндэслэлээр намыг удирдан явуулахад шаардлагатай төсвийг олгож болно.

Намын зорилго:

8.4 Намын зорилго буюу үйл ажиллагаа нь ардчилсан, суурь, дэг журамд харшлах тохиолдолд засгийн газар Үндсэн хуулийн шүүхэд татан буулгах хүсэлт гаргаж болох бөгөөд нам нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр татан буулгана.



АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

Америкийн нэгдсэн улсын улс төрийн намууд Үндсэн хуулийг хэлэлцэх явцаас эхтэй ч "АНУ-ын Үндсэн хуульд" тусгагдаагүй боловч улс төрийн нам нь өөр өөрийн зүй тогтлын дагуу хөгжсөөр ирсэн байна.

АНУ-д үндсэндээ үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалсан Бүгд Найрамдах нам (1854 онд байгуулагдсан), Ардчилсан Нам (1828 онд байгуулагдсан) хэмээх хоёр намын тогтолцоо бүрдэж, түүхэндээ засгийн эрхийг ээлж дараалан барьсаар иржээ. Эдгээр гол хоёр намын үзэл баримтлал зарчмын ялгаа үгүй боловч БНН хувийн эдийн засагт төрийн оролцоог аль болохоор хязгаарлах чиг шугам баримтлаж байхад АН нь засгийн газар хувийн хэвшлийн эдийн засгийг тодорхой хэмжээгээр удирдан зохицуулж, хүн амын нийгмийн асуудалд анхаарах ёстой гэж үздэг байна. Энэ хоёр намаас гадна Шинэчлэлийн нам, Ногооны болон Социал-демократ нам гэх зэрэг улс төрийн 21 нам байдаг. Тэдгээр намууд улс төрийн нөлөө байхгүй, өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаггүй байна.

INFO
MIGRANTS
 German election
 2025



ХБНГУ-ЫН БУНДЕСТАГИЙН СОНГУУЛИЙГ АЖИГЛАЛАА

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Бундестагийн сонгуулийн санал хураалт 2025 оны 2 дугаар сарын 23-ны өдөр боллоо.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, гишүүн Д.Баяндүүрэн нар ХБНГУ-ын Холбооны сонгуулийн хорооны хуригаар Бундестагийн 21 дэх

удаагийн сонгуулийн үйл явцыг ажиглав.

Сонгуулийн урьдчилсан дүнгээр Христийн ардчилсан нам /Христийн нийгмийн холбоо (CDU/CSU) Бундестагийн нийт 630 суудлаас 208-д ялалт байгуулж, хамгийн олон суудлыг авсан байна. Түүнчлэн Германы өөр сонголт нам (AfD) 20.6

хувь, Социал демократ нам (SPD) 16.5 хувь, "Grüne" буюу Ногоон нам 11.6, Зүүний нам 8.8 хувийн санал авчээ.

Энэ удаагийн сонгуулийн санал хураалт 1990 оноос хойших хамгийн өндөр ирцтэй, олон нийтийн идэвх сайн байсныг ажиглагчид онцолсон юм.

“ХИЙМЭЛ ОЮУН УХААН-СОНГУУЛЬД ОРОЛЦОГЧ ТАЛУУД” СЕМИНАРТ ОРОЛЦОВ

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ Малайз улсын Куала Лумпур хотноо 2024 оны 11 дүгээр сарын 18-20-ны өдөр болсон “Хиймэл оюун ухаан-Сонгуульд оролцогч талууд” сэдэвт семинарт оролцлоо. Уг арга хэмжээг Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн /International IDEA/ нь Microsoft болон OpenAI компаниудын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан юм.

“Хиймэл оюун ухаан-Сонгуульд оролцогч талууд” семинарт Азийн улс орнуудын сонгуулийн удирдлагын байгууллагаас гадна иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн салбарын 30 гаруй төлөөлөл оролцов.

Энэхүү семинараар хиймэл оюун ухааныг хэрхэн бүтээж, ажиллуулдаг талаарх үндсэн ойлголт болон “Хиймэл оюун ухаан ёс зүй ба хүний эрх”,

“Хиймэл оюун ухаан ашиглан бүтээсэн контент, үйлчилгээ”, “Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан ашиглах боломж” зэрэг сэдвийг хэлэлцүүлсэн юм.

Мөн хиймэл оюун ухаан ашигласан

худал мэдээллийг хэрхэн зохицуулах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар хэлэлцүүлэхийн зэрэгцээ энэхүү шинэ сорилтыг сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хэрхэн үр дүнтэй ашиглаж болох талаар санал, хувилбаруудын талаар хэлэлцэв.





ШИНЭ НОМ

"Сонгуулийн боловсрол" онол, арга зүйн сэтгүүл сонгуулийн эрх зүйн хөгжилд ач холбогдолтой шинэ номыг цувралаар танилцуулж эхэллээ.

- » Энэ удаад Академич Ж.Амарсанаагийн "ХУУЛИЙН ДАГАЛГА" номыг онцолж байна.
- » Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь II. Д-А. Хамтын. Уб.,2008 *Дагалга-1. Дагах үйл; 2. Ном бичгийн доторх үг өгүүлбэрийн утгыг тайлбарласан зүүлт, нэмэлт дагалдуулга; дагалга бичих (зүүлт, тайлбар бичих), дагалга үг (тайлбарлан тодруулсан үг).
- » Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. Нэмж дэлгэрүүлсэн тавдугаар хэвлэл. Уб., 2023. *Дагалга-Ном бичгийн доторхи үг өгүүлбэрийн утгыг тайлж тайлбарласан үг, өгүүлбэр; дагалга үг.

Академич Ж.Амарсанаа "Хуулийн дагалга" номынхоо Угтал үгэнд "...Сүүлийн үед батлагдсан ихэнх хуульд "Нэр томъёоны тодорхойлолт" гэсэн бие даасан зүйл бичих болжээ. Чухамхүү тухайн хуульд орсон үгийг хэрхэн ойлгох талаар бичсэн энэхүү тодорхойлолтыг бид "дагалга" гэж ярьж, бичээд байгаа юм" гэж тайлбарлажээ.

Оюутан, сонсогч, судлаач, багш, цэцийн гишүүн, шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, хууль сахиулах байгууллагын ажилтан, төрийн ба төрийн бус байгууллагад ажиллагчид, бизнесийн салбарынхан, ер нь хууль хэрэглэдэг хэн ч боловч ашиглаж болохуйц уг номыг 2025 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийг үндэслэн бэлтгэсэн байна. Тодруулбал, 281 хуулийн дагалгыг эмхэтгэснээрээ уншигч Таны эрж хайх, судлах, мэдээлэл авах ажлыг хөнгөвчлөх юм.



Уншигч Та "Хуулийн дагалга" номыг
Хууль зүйн академиас авах боломжтой.

Утас: 94048143



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НӨХӨН СОНГУУЛЬ-2025

САНАЛ ТЭМДЭГЛЭХ ЗААВАР

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ

САНАЛЫН ХУУДАС

аймаг/нийслэл, сум/дүүрэг, _____ байрхороо
_____ дугаар хэсэг

"АЙМАГНИЙСЛЭЛ"-ийн иргэдийн төлөөлөгчдийн хурал

Та өөрийн сонгохыг хүссэн 3 нэр дэвшигчийн өмнөх зууван улаан дугуйг дүүргэн будаж саналаа тэмдэглэнэ үү. 3-с илүү нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн бол саналын хуудсыг хүчингүйд тооцож анхаарна уу.

Ном 1	Ном 2	Ном 3
☐ Дэвшигчийн нэр НЗР	☐ Дэвшигчийн нэр НЗР	☐ Дэвшигчийн нэр НЗР
☐ Дэвшигчийн нэр НЗР	☐ Дэвшигчийн нэр НЗР	☐ Дэвшигчийн нэр НЗР
☐ Дэвшигчийн нэр НЗР	☐ Дэвшигчийн нэр НЗР	☐ Дэвшигчийн нэр НЗР

Бид эцэс нэр дэвшигч

☐ Дэвшигчийн нэр НЗР	
☐ Дэвшигчийн нэр НЗР	
☐ Дэвшигчийн нэр НЗР	

"СУМ/ДҮҮРЭГ"-ийн иргэдийн төлөөлөгчдийн хурал

Та өөрийн сонгохыг хүссэн 1 нэр дэвшигчийн өмнөх зууван улаан дугуйг дүүргэн будаж саналаа тэмдэглэнэ үү. 1-с илүү нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн бол саналын хуудсыг хүчингүйд тооцож анхаарна уу.

Ном 1	Ном 2	Ном 3
☐ Дэвшигчийн нэр НЗР	☐ Дэвшигчийн нэр НЗР	☐ Дэвшигчийн нэр НЗР
☐ Дэвшигчийн нэр НЗР		

Та мандатын тооноос
илүүгүй нэр дэвшигчийн
өмнөх зууван дүрсийг
дүүргэн будаж саналаа
тэмдэглэнэ.

САНАЛЫН НУУЦЛАЛЫН
ХАВТАС

АШИГЛАХ ЗААВАР:

- Саналаа тэмдэглэхийг дараа саналын хуудсаа хаяхтай хийнэ.
- Хавтасны 2 хажуу талыг борж, саналын хуудсаа снэлэ тоолж төлбөрийг хуудсанд уншуулав.
- Хавтасны хэсгийн зөрөөг ажигланг өгнө.

САНАЛАА ӨГСӨН СОНГОГЧ ТАНД БАЯРЛАЛАА

Сонгогч та саналын хуудсаа "САНАЛЫН НУУЦЛАЛЫН ХАВТАС"-т
хийж санал тоолох төхөөрөмжид уншуулснаар таны өгсөн саналыг
ТАНААС ӨӨР ХЭН Ч МЭДЭХ БОЛОМЖГҮЙ.

СОНГОГЧ ТАНЫГ САНАЛАА
ӨГӨХИЙГ УРЬЖ БАЙНА.

2025.06.22
07:00-20:00

(Улаанбаатарын цагаар)

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО





МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:
gecm@m-election.mn
(976) -51 262127

UIH.MN
СУДАЛГААНЫ САН